

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-10
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	11-39
1. Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	11-39

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
12 дугаар сарын 23-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 27 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 51.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 22 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Л.Мөнхбаатар;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Х.Баттулга, Б.Дэлгэрсайхан, С.Одонтуяа, М.Нарантуяа-Нара;

Тасалсан: Ж.Баярмаа, Д.Пүрэвдаваа.

Нэг.Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Я.Жавхлан, мөн газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Банк, санхүүгийн хэлтсийн дарга Ө.Мөнх-Ундарга, мөн газрын ахлах мэргэжилтэн М.Батсайхан, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон улсын Арбитрын ерөнхий нарийн бичгийн дарга М.Шинэбаяр, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын ахлах бүртгэгч Б.Гэрэлзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Н.Алтанхуяг, П.Сайнзориг, С.Цэнгүүн, Ц.Сандаг-Очир, Л.Соронзонболд, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Д.Мөнх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Оюунзул нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Х.Тэмүүжин, О.Номинчимэг, Л.Соронзонболд, Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Д.Цогтбаатар: 1.Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы

нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболдын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Арбитрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Векселийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 9
Бүгд: 19
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 8

Бүгд: 19

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 8

Бүгд: 19

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12

Татгалзсан: 7

Бүгд: 19

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 7
Бүгд: 19
63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 18 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 48 минут үргэлжилж, 27 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 70.4 хувийн ирцтэйгээр 18 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 23-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
16 цаг 22 минут.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Д.Цогтбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг эрье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Дамдины Цогтбаатар, Норовын Алтанхуяг, Хүрэлбаатарын Баасанжаргал, Энхбаярын Батшугар, Баярмагнайн Баярбаатар, Одсүрэнгийн Номинчимэг, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Буяагийн Тулга, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар гэсэн ирцтэйгээр 51,9 хувиар ирц бүрдсэн байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу. Хэлэлцэх асуудлаар санал байгаа юу. Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Энхбаяр танилцуулна. Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 38-д хуулийн этгээдийн төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох, төлбөрийн чадваргүйдлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх, нэхэмжлэлийн шаардлага гаргах, түүнийг хангах, хэрэг гүйцэтгэгчийн эрх хэмжээ, түүнийг томилох, чөлөөлөхтэй холбоотой зохицуулалт, үүрэг гүйцэтгүүлэгчдийн хурал, түүний эрх хэмжээ, төлбөрийн чадваргүй хуулийн этгээдийг дахин зохион байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааны зохицуулалтыг боловсронгуй болгох зорилтын хүрээнд Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан.

Дампуурлын тухай хууль нь 1997 онд батлагдсан бөгөөд түүнээс хойш зарчмын шинжтэй бие даасан шинэчлэл хийгдээгүйгээр 28 дахь жилдээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Хуулийг хэрэглэх, хэрэгжүүлэх явцад практикт тодорхой хүндрэл, зөрчил илэрч, төлбөрийн чадваргүйдлийн харилцааг зохицуулах өнөөгийн олон улсын чиг хандлага, стандарт, зарчимтай нийцэхгүй болсон талаар дотоод, гадаадын судалгааны байгууллагуудын дүгнэлт, олон улсын байгууллагын санал, зөвлөмжүүдэд удаа дараа дурдсан байдаг. Үүний дагуу Дампуурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, уг хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан болно.

Эдгээр үндэслэлийг харгалзан Дампуурлын тухай хуулийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн орчин үеийн аргачлал, стандарт, суурь зарчмын дагуу шинэчлэн боловсруулж, дараах зарчмын шинжтэй өөрчлөлтүүдийг тусгалаа. Үүнд,

1 дүгээрт, хуулийн төслөөр хуулийн этгээдийн төлбөрийн чадвартай эсэхийг тогтоох, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэх, төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээдийг дахин хөрөнгөжүүлэх, татан буулгах, түүнчлэн төлбөрийн чадвартай боловч санхүүгийн хүндрэлд орж, төлбөрийн үүргээ зогсоосон хуулийн этгээдэд төлбөрийн чадваргүйдлээс урьдчилан сэргийлэх бүтцийн өөрчлөлт хийхтэй холбоотой харилцааг цогцоор нь зохицуулахаар тусгалаа.

2 дугаарт, банкны системийн онцлогийг харгалзан банкны дампуурлын харилцааг банкны салбарын тусгай хуулиар зохицуулахаар хэвээр үлдээж, даатгал, банк бус санхүүгийн байгууллага зэрэг санхүүгийн байгууллагын төлбөрийн чадваргүйдэлтэй холбоотой нарийвчилсан харилцааг салбарын холбогдох хуулиар, нийтлэг харилцааг энэхүү хуулиар зохицуулахаар тусгасан болно.

3 дугаарт, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд төлбөрийн чадваргүйд тооцох үндэслэлийг хуулийн этгээдийн өөрийн хөрөнгөтэй уялдуулан тодорхойлсныг олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж, бэлэн мөнгөний урсгалын арга болон балансын аргыг хослуулсан шалгуураар төлбөрийн чадваргүйдлийг тогтоохоор төсөлд тусгалаа.

4 дүгээрт, нэхэмжлэлийн шаардлагыг баталгаажуулах ажиллагааг хуульд нарийвчлан зохицуулаагүйгээс нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа үндэслэлгүйгээр нэмэгдүүлэх сөрөг практик бий болсон тул нэхэмжлэлийн шаардлага гаргах, баталгаажуулах, хангуулахтай холбоотой ажиллагааны зохицуулалтыг бүрэн шинэчлэн боловсрууллаа.

5 дугаарт, төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээдээс авлагатай нэхэмжлэгчдийн эрхийг тэгш хангах, аль болох олон нэхэмжлэгчийг ажиллагаанд хамруулах зорилгоор нэхэмжлэгч нарт мэдээлэл хүргэхтэй холбоотой зохицуулалтыг илүү өргөн хүрээнд тодорхой болгож тусгалаа.

6 дугаарт, дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол оролцогч болох хэрэг гүйцэтгэгчид тавигдах шаардлага, түүний эрх, үүрэг, томилгоо, урамшуулал, хариуцлагын зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, хэрэг гүйцэтгэгчийн эрх зүйн байдлыг тодорхой болголоо.

7 дугаарт, дампуурлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь онцгой болон ердийн ажиллагааны аль алиных нь шинжийг агуулдаг онцлогтой тул уг процессын зохицуулалтыг хуулийн төсөлд нарийвчлан тусгаж, энэ хуульд заагаагүй харилцааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулахаар тусгалаа.

8 дугаарт, хуулийн төсөл нь төлбөрийн чадваргүй болсон хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, татан буулгахаас гадна дахин зохион байгуулж, үйл ажиллагааг нь сэргээх, мөн төлбөрийн чадваргүйдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн харилцааг зохицуулах зорилготой тул хуулийн нэрийг олон улсын жишигт нийцүүлэн Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль болгож өөрчилсөн болно.

Хуулийн төсөл батлагдсанаар зах зээлийн эдийн засгийн зайлшгүй үзэгдэл болох төлбөрийн чадваргүйдлийн асуудлыг олон улсын жишигт нийцсэн, үр нөлөөтэй эрх зүйн орчноор зохицуулах боломж бүрдэж, санхүү, зах зээлийн харилцааны ил тод байдал, хариуцлага дээшлэхийн зэрэгцээ эдийн засгийг цэвэршүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Хуулийн төслийг дагалдуулан хуулийн нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан 33 хуулийн төсөл, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай зэрэг нийт 40 хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Энхбаяр сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Мөнх-Эрдэнэ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Жавхлан, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Банк, санхүүгийн хэлтсийн захирал Мөнх-Ундарга Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Оюунзул, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын ахлах мэргэжилтэн Батсайхан, Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын олон улсын арбитрын Ерөнхий нарийн бичгийн дарга Шинэбаяр, Улсын Бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын ахлах бүртгэгч Гэрэлзул гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг өнөөдрийн хуралдаанд оролцож байна.

Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Ганбат гишүүнээр тасаллаа. Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Энэ хуулийг бол үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа. Олон жил бас судалж хийж байсан. Олон ч удаагийн хэлэлцүүлэгт нь оролцож бас байсны хувьд энэ хуулийг Улсын Их Хурал дээрээ хэлэлцээд гарах хугацаа нь болсон гэж үзэж байгаа. Ер нь энэ Төлбөрийн чадваргүйдлийн тухай, дампуурлын асуудлаа хууль, эрх зүйн хүрээнд цэгцлэхгүй бол эдийн засгийн хувьд тодорхой байдал байхгүй. Үр ашиггүй байдал үргэлжилсээр байна. Эцсийн эцэст төлбөрийн чадваргүй гэж байгаа ч гэсэн гол энэ хуулийн чинь утга, концепц нь болохоор, хуулийн хувьд ч, санхүүгийн хувьд ч, нийгмийн хувьд ч гэсэн тэгш, шударга ёсыг тогтоох, тэгш хуваарилалт, шударга ёсыг тогтоох, тогтвортой байдал буюу

урьдчилсан predictability буюу тодорхой байдлыг л санхүүгийн хувьд, эдийн засгийн хувьд бий болгох гээд байгаа. Тэгээд тийм юм байхгүйгээс үүдээд эрсдэлээ тооцох чадвар гэх мэт асуудлууд манай энэ бизнесийн салбар, эдийн засгийн салбарт маш их удаан даамжирсан. Тэгэхээр энийг бол цааш нь хэлэлцээд явах нь зүйтэй гэж харж байгаа. Энэ дээр яах вэ, хууль дээр 1 асуулт байна.

Дампуурлын тухай хууль гэж байгаад дээр үеийн 1997 оны хууль. Маш их цаг үеэсээ хоцорчихсон, процесс дээр, бодит байдал дээр ерөөсөө ажиллаж чаддаггүй, асуудлаа шийдэж чаддаггүй хууль болчихсон нь үнэн. Шүүх дээр ч гэсэн компанийг татан буулгах гээд дампууруулах гээд явахад бол энэ хэзээ ч шийдэгдэхгүй. Дандаа баахан зомби компаниудтай болчихсон. Тэгэхээр энэ төлбөрийн чадваргүйдэл миний ойлголтоор бол төлбөрийн чадваргүйдэл гэдэг бол өөрөө хуулийн ийм концепцын framework. Энэ чинь бүх процессыг оруулж байгаа. Түүний дотор нэг арга хэрэгсэл хамгийн эцсийн шат бол уг нь дампуурал. Тэгээд дампуураад, дампуурсны дараа процесс тэгвэл энэ чинь яаж явах вэ гэдэг бас маш нарийн зохицуулалт байдаг. Тэгээд энэ хуулийг харахаар төлбөрийн чадваргүйдэл урьдчилан сэргийлэх арга хэмжээ, дахин зохион байгуулалтын асуудлууд, процессууд нэлээн нарийвчилж орсон боловч яг дампуурах шийдвэр гараад, тэрнээс хойш яах вэ гэдэг юм тусгагдаагүй юм шиг харагдаад байгаа юм.

Тэгээд дагасан хууль дээр харахаар бас дампуурлын 1997 оны хуулийг хүчингүй болгох хууль орж ирээгүй юм шиг харагдаад байгаа юм. Тэгээд энийг ер нь дампуурлын энэ процессоо яаж ер нь шийдье гэж байгаа юм. Энэ хуулиараа бүтэн шийдье гэж байгаа юм уу, давхар процесстой явна гэж харж байгаа юм уу. 1 дүгээрт энэ дээр тодруулга авъя. Энэ л асуудлыг ерөнхийдөө хараад, шийдээд нэр томъёогоо цэгцэлчих юм бол энийг бас Улсын Их Хурал хурдан гаргаж, бизнес эдийн засгийн харилцаанд орж байгаа хүмүүстээ тодорхой байдлыг үүсгэх хэрэгтэй байна.

2 дахь асуудал. Энэ дээр бол нөгөө хувь хүний төлбөрийн чадваргүй байдлын тухай хууль орж ирээгүй. Энэ зөвхөн аж ахуйн нэгжүүд дээр ярьж байгаа. Хувь хүний төлбөрийн чадваргүйдлийг тогтоох асуудлыг хэлэлцэхэд ер нь манай нийгмийн одоогийн байдал, хөгжлийн асуудал бэлэн биш байна гэж үзэж байна уу. Хувь хүний дампуурал, хувь хүний төлбөрийн чадваргүйдлийн асуудлыг ер нь яах ёстой гэж бодож байгаа вэ гэдэг 2 асуултыг хууль санаачлагчаас асууя.

Д.Цогтбаатар: Саяын энэ асуултад сайд хариулах уу. Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Тэгээд ажлын хэсгээс бас дэлгэрүүлж хариулах зүйл байвал дэлгэрүүлээд хариулахад нь зүйтэй. 28 жил бол бид Дампуурлын тухай хууль гэдэг хуулиар явж ирсэн байна. Энэ бол анх тэр 1996 онд ер нь энэ тухайн үеийн Сэргээн босголт банкны хэрэг гэж том хэрэг үүсэж байсан. Тэрнээс өмнө нэлээн хэдэн банкнууд дампуурсан байсан. Энэ нөхцөл байдал дээр ер нь энэ Дампуурлын хууль ер нь хэрэгтэй юм байна. Тэгэхгүй бол их олон хүний хөрөнгө, эд хогшлыг яах вэ гэдэг асуудал үүссэн юм байна гээд ингээд явжээ. Дампуурлын хууль маань үндсэндээ захиргааны санаачилгаар дампууруулах чиглэгдсэн. Тухайн үедээ одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль маань бол 30 орчим зүйлтэй ийм хууль явж ирсэн байна. Энэ хуулиар явахаар саяын яг Номинчимэг гишүүний асуугаад байгаа бидний өнөөдрийн дампуурах, төлбөрийн чадваргүйдэл гэсэн энэ 2 харилцааг ер нь эрх зүйн хувьд нь ч тэр, практик хувьд нь ч тэр сайн ойлгохгүй, хүчээр дампууруулахад чиглэгдсэн ийм

харилцаагаар бид 30 жил явчихсан байгаад байгаа юм. Одоо бол бид нар шүүх дээр илүүтэй захиргааны санаачилгаар биш, илүү шүүх тухайн төлбөрийн чадваргүй болсон нөхцөл байдлыг үнэлж, тухайн хүнийг илүү харин дампуурахгүй байхаас нь илүү урьдчилан сэргийлэх нэг талаас, нөгөө талаасаа тэр хөрөнгийн дутагдалд орсон асуудлаас нь хурдан гаргаж, буцааж амилуулах тэр чиглэлд нь илүү чиглэсэн олон улсын сайн туршлагыг процессжуулж оруулж ирсэн байгаа юм. Ингээд оруулаад ирэхээр таны асууж байгаа асуулт яг хөндөгдөнө. Өөрөөр хэлбэл энэ хувь хүний төлбөрийн чадваргүйдлийн асуудлыг яах юм бэ. Иргэд хоорондоо зээл, барьцаа, арилжаа хийгдээд, төлбөрийн чадваргүй болчихсон, төлөхгүй байгаа. Эндээс үүссэн харилцааг яах вэ гэдэг харилцаа, энэ бол том орон зай гарч ирнэ.

Нөгөө талаас мөн таны асууж байгаа энэ захиргааны санаачилгаар хашилтад хэлээд байгаа шүү би дампууруулах гэж. Өөрөөр хэлбэл энэ Х тайлан өгдөг, татвараас зайлсхийгээд байгаа юм уу, эсвэл үнэхээр тийм эрсдэлд ороод тайлангаа төлөхгүй байгаад байгаа юм уу. Яг компанийг нь үзэхээр тендерт ороод орлого олоод байдаг. Цаашаа худалдан авалт хийгээд байдаг. Тэгсэн мөртөө төлбөрөө төлдөггүй. Энэ 2 харилцааг яах вэ гэдэг асуудлыг одоогоор бол тодорхойлоогүй. Улсын Их Хурал дээр энэ хуультай зэрэгцүүлээд хэлэлцүүлгийн шатанд явахад би бол нөхцөл байдлыг үнэлээд, бие даасан хуулийн хэлбэрээр тусдаа орж ирэх харилцаа болов уу гэж бодож байгаа.

Цаг хугацааны хувьд хэзээг би бол үнэлж мэдэхгүй. Гэхдээ ер нь энэ хувь хүмүүсийн хоорондын төлбөрийн чадваргүйдлийн асуудлыг бид хойш нь тавиад л байх юм бол энэ бас их сайн зүйл рүү хүрэхгүй байх. Бэлэн болчихсон цаг хугацаа гэж мэдээж байхгүй байх. Бэлэн, яг тохиромжтой цаг хугацаа гэж бол байхгүй байх. Би бол цаг хугацааны хувьд бол нөхцөл байдал бүрдэж байгаа байх. Энэ хуулийн хэлэлцүүлгийн шатад ч гэсэн олон талаас нь ярихад саяын ярьж байгаа, таны асууж байгаа энэ хувь хүний төлбөрийн чадваргүйдлийн асуудлыг ер нь зохицуулах ёстой гэдэг энэ хэрэгцээ шаардлага улам бас товойж гараасай гэж бодож байгаа. Парламент дээр.

Д.Цогтбаатар: Мөнх-Эрдэнэ дарга индэр лүү гараад хариулъя. Индэрийн микрофоныг өгөөрэй.

Д.Мөнх-Эрдэнэ: Хууль зүйн байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг эрин мэндчилье. Номинчимэг гишүүний асуултад хариулъя.

Юуны түрүүнд бол энэ өмнө, одоо үйлчилж байгаа хуулиа хүчингүй болгох хуулийн төслийг бол бид боловсруулсан байгаа. Энэ дээр 38 дугаар хуудсан дээр байна. Яг үүрэг гүйцэтгэгчийг дампууруулахтай холбоотой харилцааг нь 9 дүгээр бүлэг дээр нэхэмжлэлийн шаардлагыг хангах, хуваарилалтын ажиллагаа, төлбөрийн чадваргүйдлийн ажиллагааг дуусгавар болгох, зогсоох гэсэн энэ бүлэг дээр, бүлэг дотроо 91, 92 дугаар зүйлээр зохицуулж байгаа гэж хэлье. Баярлалаа.

Д.Цогтбаатар: Алтанхуяг гишүүнд микрофоныг өгье. Би 2 ширхэг танин мэдэхүйн юм асууя. Эхнийх нь болохоор Номинчимэг гишүүнийхтэй их төсөөтэй. Би нэр томъёог чинь сайн ойлгохгүй байсан чинь төлбөрийн чадваргүйжилт гэж их ерөнхий утгатай юм ойлгочихлоо. Энэ нь дотроо хэд хэдэн үе шаттай байх юм байна. Тэрний төгсгөлийн шат нь бол хуучны бидний ярьж заншсан дампуурал гэдэг юм байна гэж ойлгож байгаа. Энэ зөв үү. Би зөв ойлгоод байна уу. Болдог тэр үе шатуудыг нь хэлэх арга байна уу. Энэ хууль дээр юу гэж байгаа юм бол.

2 дахь нь хувь хүний төлбөрийн чадваргүйжилтийн асуудал тусдаа гээд ингээд хэлчихлээ. Энэ дээр үеийн зарим банкнуудын дампуурлыг би харж байхад хувь нийлүүлэгчид нь өөрснөө хувь руугаа юм уу, ойр хавийнхан руугаа баахан зээлүүдээ гаргаад, тэгээд банк гэдэг нь өөрөө төлбөрийн чадваргүйжилттэй болчихоод байгаа байхгүй юу. Тиймэрхүү юм энэ дээр бас байхгүй юм уу. Алтанхуяг гэдэг нөхөр энэ чинь 1 ийм бүхэл организмын 1 хэсгийг нь авч яваад, аж ахуйн нэгж гээд. Тэнд байгаа 1 элемент болох Алтанхуяг гэдэг этгээд чинь тийшээгээ юмнуудаа гулсуулаад, нөгөө объект, хуулийн этгээд нь дампуурах гэдэг юм уу, төлбөрийн чадваргүй харагдаад байх иймэрхүү процесс байдаг юм уу. Би ер нь мэдэхгүй юм асууж байна шүү. Бид нар бол өмнө 1997 онд тэр дампуурал гээд л ингээд төгсгөлөөр нь нэрлээд, өөрсдөө дампууруулаад дуусацгаасан л даа. Тэгэхээр одоо бол зөв, зүйтэй юм руугаа явах гэж байх шиг байна. Тэгэхдээ би танин мэдэхүйн ийм 2 юм л асуучих гэсэн юм.

Д.Цогтбаатар: Энхбаяр сайд хариулъя.

Б.Энхбаяр: Манай Алтанхуяг гишүүн бол хэзээ ч дампуурахгүй ийм хүн байгаа. Хариуцлагатай. Энэ хуулийн төсөл дээр сая үндэслэл хэсэгт ярьсан төлбөрийн чадваргүйд тооцох үндэслэл гэдэг дээр балансын шалгуур, бэлэн мөнгөний урсгалын шалгуур гэсэн 2 аргыг зэрэг хэрэглээ гэдэг ийм хуулийн концепц оруулж ирж байгаа юм. Балансын шалгуур, бэлэн мөнгөний урсгалын шалгуур гэж ер нь яг юу яриад байна вэ гэхээр яг таны асууж байгаа энэ төлбөрийн чадваргүйд тооцох асуудлыг хэн мэдэх боломжтой вэ гэдэг асуудал байгаа. 2 хуулийн этгээд гэрээний үүргээ биелүүлж чадахгүй нөхцөл байдалд ороод байна. Үнэхээр санаатай хийгээд байна уу, эсвэл залилан мэхлэх бүр гэмт хэргийн сэдэлтэй хийгээд байна уу, эсвэл татвараас зайлсхийх сэдэлтэй хийгээд байна уу. Үнэхээр нөхцөл байдлын улмаас ийм төлж чадахгүй нөхцөл байдал байна уу гэдгийг нөгөө этгээд яаж мэдэх бололцоотой юм бэ. Тэр дансны үлдэгдлийг нь шалгах бололцоо байхгүй байгаад байгаа юм. Яагаад гэхээр дансны үлдэгдлээ тухайн хүн өөрөө л мэдэж байгаа. Тэгэхээр энийг яаж мэдэх бололцоотой юм бэ гэж. Тэгэхээр энийг банкны бэлэн мөнгөний урсгал, балансын шалгуур гэсэн энэ 2-ыг хослуулж байж энэ үнэхээр төлбөрийн чадваргүй болчихсон этгээд мөн байна уу, үгүй юу. Энэ этгээд бүрмөсөн амиа хорлох хэмжээнд хүрчхээд байна уу. Энийг харин яаралтай аврах ажиллагааг эхлүүлэх боломжтой байна уу, үгүй юу гэдгийг хийх гэж энэ хуулийн төсөл ийм дэлгэрэнгүй процесстойгоор бичигдсэн байгаа. Энэ бол ер нь 1997 оны нэршлээр нь бол Дампуурал гэж нэрээр нэрлээд байгаа болохоос биш энэ ер нь хүнийг дампуурахаас аврах тухай хууль яриад байгаа юм. Яг доторх энэ хуулийн агуулга одоогийн хуулиас ялгаатай нь нөгөөдөх нь хүнийг сая Номинчимэг гишүүн их гоё хэллээ шүү дээ. Зомби гэж яг зомби болгочхоод байгаа байхгүй юу. Амьд ч биш, үхдэл ч биш ийм зомби болгоод байхгүй. Тэрийг буцааж амилуулах, яавал хурдан амилуулах вэ гэдэг чиглэлд ийм хөшүүргүүдийг хийгээд, тэгээд тэр хүнийг бүрмөсөн эдийн засаг, нөхцөл байдлын хувьд, нийгмийн амьдралын хувьд ч гэсэн тусгаарлагдахгүй байх тэр боломж нөхцөлийг яаралтай хууль зүйн хувьд нь бүрдүүлэхэд чиглэгдсэн ийм процесс байгаад байгаа юм. Тэгээд энэ дээр яах вэ, үүний шаардлага, хэрэгцээ шаардлага гэхээр жишээлбэл, төлбөрийн чадваргүйдлийг мэдэх боломжгүйгээс үүссэн үр дагаврыг шүүхийн case study дээр 2006-2016 оны байдлаар 10 жилийн хугацаанд шийдсэн хэргийн шийдвэрлэлтээс авч үзэхэд нийтдээ 20,7 тэрбум төгрөгийн шаардлагаас зөвхөн 1 хувь нь хангагдсан байгаа юм. Энэ юу хэлээд байна вэ гэхээр тухайн төлбөрийн чадваргүй болсон этгээдийг аврах, нөгөө талдаа тэр хохирогч, хохирогч гэж хэлнэ шүү дээ. Тэр хохирохгүй байх тэр нөхцөлийг манай энэ дампуурлын хууль гүйцэтгэж чадахгүй байна л гэсэн үг. Ерөөсөө 1 хувийг л барагдуулж чадаж байна гэдэг бол өөрөө

ерөөсөө энэ хуулийн зорилго нэгэнт биелж чадахгүй, энэ хуулиар бид цаашаа явах боломжгүй гэдгийг өөрөө шууд илтгэж байгаа ийм статистик үзүүлэлт байгаад байгаа юм.

Тэгээд ажлын хэсэг нэмээд хариулбал хариулаарай. Гараа өргөөд.

Д.Цогтбаатар: Мөнх-Эрдэнэ даргын индрийн микрофон өгье.

Д.Мөнх-Эрдэнэ: Алтанхуяг гишүүний асуултад хариулъя. Таны асууж байгаа яг зөв. Энэ нөгөө төлбөрийн чадваргүйдэл гэдэг харилцааг энэ Дампуурлын хуулийн агуулга бас тодорхой гаргаж өгөхгүй байсан. Юуны түрүүнд л нөгөө дампууруулаад, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох нь чухал юм шиг ийм агуулгаар 1997 оны хууль бичигдсэн байсан бол энэ хууль дээр бол *insolvency* гэж нөгөө төлбөрийн чадваргүйдэлд тэр шүүх оролцохоос өмнө буюу ер нь энэ хүн энэ хуулийн этгээд хүлээсэн үүргээ, бусдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй гэсэн энэ нөхцөл байдал үүсчихсэн байгаа. Энэ үедээ бол энэ хуулийн этгээд банк зээлдүүлэгч ч юм уу бусад этгээдүүдтэй хэлэлцээнд орж, шүүхийн өмнөх шатад энэ асуудлаа шийдвэрлэх боломж нь бас байж байдаг. Тэгвэл шүүх оролцоод ирвэл энэ дампуурлын процесс ер нь олон улсын жишгээр ингээд эхэлдэг. Тэгэхээр бид бол энэ хуулийн төслийг боловсруулах явцад хийсэн судалгаануудаас харахад бол дийлэнх оронд энэ нөгөө *insolvency* гээд төлбөрийн чадваргүйдлийн хууль гэдэг агуулгаар хуулиудаа нэрлэсэн байдаг. Зарим улсад нь болохоор төлбөрийн чадваргүйдлийг болон чадваргүйдлийн ба эсвэл дампуурлын гэж аль алинаар нь нэрлэсэн ийм тохиолдлууд байна. Ерөнхий энэ хуулийн концепц, үзэл баримтлал бол хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоохоосоо илүү боломж олгож, дахин хөрөнгөжүүлэх, эсвэл дахин зохион байгуулах замаар тэр өр төлбөрт орчхоод байгаа нөхцөл байдлыг сайжруулах, тэр үүрэг гүйцэтгүүлэгч, нэхэмжлэгч талуудын эрх ашгийг хангах, нөгөө талаасаа тухайн хуулийн этгээдийг ч гэсэн тэр байгаа боломж дээр нь дахин боломж олгож, энэ үйл ажиллагааг нь хэвийн үргэлжлүүлэх боломжийг олгох нөхцөл байдлыг энэ хуулиар зохицуулах нь түлхүү анхаарч байгаа концепцтой учраас ингэж энэ хуулийнхаа концепцод олон улсын жишгийг харгалзан бид Төлбөрийн чадваргүйдлийн хууль гэж нэрлэсэн.

Тэгээд энийг бас харуулж байгаа нэг зүйл бол 2006-2016 онд явуулсан манай судлаачдын хийсэн судалгаа байна лээ. Эндээс харахад 39 жишээ нь тодорхой дампуурлын хэрэг дээр судалгаа хийхэд энэ дээр ер нь 5 нь л яг үүрэг гүйцэтгүүлэгч буюу нэхэмжлэгч талаас гаргасан хүсэлт байхад, 34 нь бол жишээ нь яг тухайн хариуцагч, хуулийн этгээд компани нь өөрөө хурдан энэ өр төлбөрөөс зайлж дампуураад, алга болоод өгөх юм бол болох нь гэсэн байдлаар хандсан. Өөрөөр хэлбэл нөгөө үүргээс зугтаасан маягаар ингэж энэ хуулийн заалтыг ашиглаад байгаа нь бид энэ хуулийг шинэчлэн найруулах, өөрчлөх гол, зорилго үндэслэл болсон юм. Тэгээд энийг өөрчлөх гэж энэ олон улсын жишгээрээ болон хуулийнхаа концепцын дагуу төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль төсөл гэж нэрлэсэн.

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Хуулийн төслийг бол хэлэлцэхийг дэмжиж байна. Өнөөдөр бас Улсын Их Хурал, Засгийн газрын түвшинд ч гэсэн бизнесийн эрх чөлөө, эдийн засгийн эрх чөлөөний тухай асуудал ярьж байгаа бол энэ хууль хамгийн чухал байгаа. Бизнес хийж эхлэх нэг хэрэг. Энэ бол харьцангуй гайгүй. Харин бизнесээс тодорхой түвшинд буюу яаж гарах вэ гэдэг асуудал байх ёстой. Энэ нь өөрөө эргээд сайн дураараа татан буугдахаасаа гадна тодорхой санхүүгийн эрсдэлүүдийг зөв

замаар хуваарилаад бас гарах асуудал байгаа. Нөгөө талдаа тухайн компани дээр үүсэж байгаа эрсдэлийг томруулахгүйгээр хуваарилж эсвэл дахин зохион байгуулалт орж тухайн компанийг, ажлын байрыг аврах асуудал байгаа. Энэ тэгэхдээ яг өмчийн эзний хүсэлтээр биш. Энэ сонирхогч этгээдийн хүсэлтийн дагуу шүүхийн оролцоотой хийдэг ажил байхгүй юу. Тэгэхээр компани гэдэг туйлын тэр хүний өмч биш гэдэг зүйлийг бид хэд бас ойлгох ёстой байгаа юм. Тийм учраас энэ төлбөрийн чадваргүйдэл дампуурлын хуулийг хийгээд хариуцлагатай бизнес хийх ёстой. Цаана нь олон хөрөнгө оруулагчдын итгэлийг аваад, хөрөнгийг нь авчхаад зүй бус менежмент хийгээд, асуудлуудыг, эрсдэлийг томруулбал энийг бага дээр нь зогсоох асуудал ерөөсөө л энэ хуулиар шийдэгдэж байгаа юм. Тэгээд 1997 онд батлагдсан хууль гараад, 1999 онд энэ хуулийг шинэчлэх ёстой юм байна гэж ажлын хэсгийн анхны дүгнэлт гараад явсан. Маш олон төслийн хувилбарууд явсан боловч сүүлд Дэлхийн банканд үзүүлэхэд энэ ерөөсөө төлбөрийн чадваргүй буюу дампуурлын асуудал ойлгодог хүн бичээгүй байна гээд бид нар тэр төслүүдийг урж хаяж байгаад, Дэлхийн банк, Ай Эф Си-ийн зөвлөхүүдтэй сууж байгаад энэ төслийг босгож ирсэн юм.

Миний хувьд бол энэ бараг миний үр хүүхдээс ялгаагүй төсөл байхгүй юу. Тэгээд энэ бас дутуу дулимаг юм бий. Энийг маш сайн ажлын хэсэг гаргаад, процессыг нь бүүр илүү их тодорхой болгоод өгмөөр байна. Энэ ерөөсөө эдийн засгийг цэвэрлэх асуудал байгаа. Энэ зомбийроод хөөрхий байхгүй болж болдоггүй. Ингээд нэг үлгэн салган, эзэд нь нийгмийн даатгал, татвар дээр байнга дуудагдаж байдаг. 2 чихнээс өөр юм байхгүй. Тэгэхээр ийм зүйлүүдийг нэг талдаа гаргаад шийдээд явах энэ асуудлыг бол хийх нь зөв байгаа юм. Тэгээд нэр томьёо ч гэсэн нэлээн бодож байж өгсөн. Энэ нэр томьёог зохиосон дараа нь хэл шинжлэлийн ухааны хүмүүстэй бас нэлээн зөвлөгөө авч байж бас ийм үг байж болох юм байна гэдэг зүйлийг тухайн үедээ бас ажлын хэсэг бас дүгнэлт гаргуулж байсан. Уулзаж байсан шүү. Дүгнэлт гэнэ. Уулзаад бас хэл шинжлэлийнхэнтэй ярилцаж хэлэлцэж байж энэ нэр томьёог авсан юм.

Тэгээд ер нь зүгээр нөгөө өөрийн хөрөнгийн дутагдал буюу тэр яг дутагдалд орж байгаа хэсэг, гуравдагч этгээд ч юм уу, сонирхогчид мэддэггүй. Бүх юм байхгүй болсны дараа юу билээ гээд явдаг. Тэгэхээр энэ дээр дампуурлын ажиллагаа эцсийн шатад орчихсон байдаг. Тийм учраас энэ дээр мөнгөн урсгалын хэмжээ буюу гэрээний үүргээ биелүүлэхгүй байгаа, тэр хэмжээ дээр мэдээ ирнэ. Чи мөнгөө өгч чадахгүй, төлбөрөө төлж чадахгүй байгаа юм бол энэ нөхцөл байдал эвгүйдсэн юм биш биз дээ гэдгийг сонирхогч этгээд мэдэх бололцоотой болж байгаа. Тэгэхээр дан ганц тэр шалгуураар биш хосолмол энэ өөрийн хөрөнгийн дутагдал болон мөнгөн урсгалын аль аль шалгуурыг нь барьж байгаа нь бас нэг талдаа бид энэ дампуурлыг бас тодорхой хэмжээнд хязгаарлах асуудал болж өгнө. Шалгуур нь болж байгаа.

2 дугаарт энэ дампуурлын хэрэг дээр 1 л зүйл байгаа. Хэрэг гүйцэтгэгч буюу .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Сайнзориг гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

П.Сайнзориг: Тэгэхээр энэ хэрэг гүйцэтгэгч гэдэг этгээдүүд байдаг. Энэ нь өөрөө ингээд компанийн захирлуудаас ур чадвар дутахааргүй хүмүүсийг бэлдэж оруулах ёстой юм. Тэгэхээр энийг хэн бэлдэх вэ гэдэг дээр бас хуулийн төсөл дээр яаж орж ирж байгаа вэ. 2 хувилбар л байдаг л даа. Хууль зүйн яам бэлдэх үү. Эсвэл энийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэд бэлдэх үү. Эсвэл Худалдаа, Аж

Үйлдвэрийн танхим хамтарч хийх үү гэдэг зүйлүүд байгаа. Тэгэхээр энэ зүйлүүд дээрээ хуулийн төсөл дээр хэрхэн яаж орж ирэв.

2 дугаарт яах вэ, өнөөдөр бол дампуурлын харилцааг 2 үндсэн хуулиар зохицуулж байгаа. Дампуурлын хууль болон Банкны хуулиар. Энд бол банкны хууль хамаагүй. Бусад хуулийн этгээдүүд орж ирж байгаа. Хувь хүний дампуурлын асуудлыг бас сайд маань хэлж байна. Энэ зөв. Энэ тэгэхдээ өнөөдөр бас хөдлөх эд хөрөнгийг банк барьцаалж байгаа бас жоохон эрсдэлүүд бол бий. Тэгээд санхүүгийн сахилга бат болон тэр иргэдийнхээ бас санхүүгийн скоринг хийдэг болчихоод бас хувь хүний дампуурал руу бас алхах зайлшгүй шаардлага байгаа. Тэгээд энэ бас шүүхийн оролцоотой шийдэж байгаа учраас арилжааны шүүх байгуулагдах зайлшгүй шаардлага байж магадгүй. Энэ дээр бас Хууль зүй, дотоод хэргийн сайд ямар байр суурьтай байгаа вэ гэж асуумаар байна. Тэгээд үе үеийн сайд нартаа бас баярлалаа. Алтангэрэл сайдыг энийг бас өргөж, Улсын Их Хуралд хэлэлцэх тэр бололцоог нь олгож өгсөнд баярлалаа. Энийг хэлэлцүүлбэ гэдэг бодлогын хувьд дэмжиж байгаа Энхбаяр сайдад бас талархаж байна. Тэгээд энэ дээр бас тал талын оролцоотой зүйлүүд дээр ажлын хэсэг гаргаад хэлэлцээд яваасай. Гол асуудал байгаа. Жоохон жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд бас жоохон томдчихсон процесс байгаа. Энийг жоохон хялбарчилмаар байгаа.

2 дугаарт нийгмийн даатгал болон татварын өрийг хэрхэн яаж цэвэрлэх вэ гэдэг дээр бас Сангийн яам болон Засгийн газартай зөвшилцөх ажил бий. Тэгэхгүй нөгөө Сангийн яам маань шүүхийн шийдвэр гараад дампуураад байчихаад байхад татварын авлага нэртэйгээр төсвийн хууль дээр нөгөө тоонуудыг баталсаар л яваа. Тэгэхээр энэ цэвэрлэгээг яаж хийх вэ гэдэг нэг том шийдлийн асуудал байгаа. Тэгээд энийг ер нь зүгээр яаралтай бас хэлэлцээд, сайтар ажлын хэсэг гаргаад яваад богино хугацаанд бас батлахыг эрмэлзэж ажиллая гэдэг бодол байна. Тэгээд саяын 3 асуултад бас Хууль зүй, дотоод хэргийн сайдыг хариулж өгөөч ээ гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Энэ хууль маань бол манай Сайнзориг гишүүний яг ориг хүүхэд нь байгаа. Тэгэхээр Сайнзориг гишүүн маань бол сайн мэдэж байгаа. Бас их олон эцэг, эхтэй. Үндсэндээ он гарвал энэ яг 10 дахь жил рүүгээ орох гэж байгаа юм. Энэ хуулийн төслийн анх судалгаа эхэлсэн байдлыг бол Дэлхийн банкны төсөлтэй 2016 оны намар энэ хуулийн төслийг боловсруулах асуудлаар санамж бичиг байгуулж, эхэлж байсан юм. Тэгэхээр би өөрөө бас дэд сайд нь байсан учраас энэ санамж бичигт гарын үсэг зурж байсан хүн өөрөө бас байгаад байгаа юм. Тийм учраас энэ их олон жилийн судалгаа, хүч хөдөлмөр байж байгаа. Би эрх зүйн тогтолцоо талаас нь бол 1 зүйлд олзуурхаж байгаа. Тэр нь манай хуульч гишүүд Тэмүүжин гишүүн ялангуяа их ярьдаг. Энэ процессын шударга ёс гэж. Хууль бол маш дэлгэрэнгүй процесстой байх ёстой, зузаан байх ёстой гэж ярьдаг. Тэгээд тэр талаасаа энэ бол манай хуулиудын дотор бас нэг тийм шинэ жишиг гаргаж байгаа хуулийн төсөл гэж би итгэлтэй хэлж чадна. Өмнөх хууль маань би хэлсэн. 30 зүйлтэй байсан бол одоо энэ хууль 160 гаруй зүйлтэй. Тэгэхэд яг энэ хуулийг зохицуулж байгаа Германы хууль гэхэд 360 зүйлтэй байгаа. Тэгэхээр бид тэр жишиг рүү өөрөөр хэлбэл илүү их процессжуулж, дэлгэрэнгүй бичих, тэр тал руу нь ойртуулж дөхүүлсэн хуулийн төсөл. Цаашид бусад хуулийн төслүүд ч гэсэн яг энэ загвар моделиор орж ирдэг байх шаардлагыг Хууль зүйн сайдын хувьд барьж ажиллана.

Энэ дээр Сайнзориг гишүүний асууж байгаа хэд хэдэн асуудал бас гүйцээх асуудал байгаа. Тухайлбал хэрэг гүйцэтгэгчийг хэн бэлдэх вэ гэж байгаа. Өөрөөр хэлбэл иргэний шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой энэ асуудал бол бас тогтолцооны асуудал байгаа. Одоо байж байгаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ийм бүтцээр Хууль зүйн сайдын харьяанд ийм захиргааны статустайгаар энэ ажиллахгүй. Тийм учраас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг миний бие маргааш Засгийн газрын хуралдаанд оруулаад татаж авах гэж байгаа. Яагаад татаж авах гэж байгаа вэ гэхээр энэ хуулийн концепцтой бас нийцүүлэх шаардлага байна. Тэгэхгүй бол уялдахгүй байгаад байна нөгөө хууль маань. Тийм учраас энд уялдуулах чиглэлээр би татаж аваад, 1 сард гялс энд боловсронгуй болгоод, 2 сарын сүүлээр хаврын чуулган эхлэхээс өмнө Их Хуралд өргөн барьчихъя. Ингээд бүтэн болгоод явах хэрэгцээ шаардлага байна. Энэ дотор тухайлбал иргэний шийдвэр гүйцэтгэгчийг ямар байдлаар өөрөөр хэлбэл төрийн хүчээр ажиллуулах вэ, хувийн хэвшилтэй хамтарсан бүтцээр ажиллуулах вэ. Энийг дагаж мөрдөхөд нэлээн хугацаа шаардах юм байна. Би яг хэлж мэдэхгүй ч гэсэн ямар ч байсан 10 жил бид нар шилжилтийн үе явах юм шиг байна. Тийм учраас дагаж мөрдөх журмын хууль дээр бид нар бас энийг тооцож, хүн хүчээ хуваарилах дээр бодож бас/минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээж хариулах уу. Энхбаяр гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

Б.Энхбаяр: Тэгж ажиллая гэсэн бодолтой байна. Мөн одоо энэ хууль дээр би иж бүрэн орж ирчихсэн. Хүссэн хэмжээнд орж ирчихсэн гэж хэлэхгүй. Ажлын хэсгийн түвшинд яг энэ хуулийг онолынх нь хувьд ч тэр бусад улс орны жишгээр боловсронгуй болгох асуудал байгаа гэдгийг бас үнэнээ хүлээж байна. Тухайлбал, манай Сангийн яам бол бүгдийг татварын орлого талын нүдээр хараад байдаг. Хүнийг үхэх боломж олгодоггүй. Үхсэн ч татварыг нь авах гээд үзчихдэг тийм нүдээр хараад байдаг. Дандаа орлого. Тийм учраас нөгөө Сангийн сайд бас үзэл баримтлал баталдаг. Улсын Их Хуралд өргөн барих зөвшөөрөл олгодог гэдэг утгаараа хуулийн этгээдүүдийн бүртгэлтэй холбоотой асуудал дээр татварын хэдэн жил дараалсан өртэй байвал гэдэг тэр шалгуураа энд биччихсэн байгаа. Энэ бол Хууль зүйн сайдын чин сэтгэлийн бодлого байгаагүй гэдгийг би мэргэжлийн Байнгын хорооныхоо гишүүдэд хэлэх гэж байна. Тийм учраас ажлын хэсгийн явцад энэ саналуудыг олон талаас нь бас яриад, боловсронгуй болгох асуудал бол байгаа гэдгийг бас хэлье.

Арилжааны шүүхийн хувьд бол мэдээж арилжааны хууль гарах ёстой. Арилжааны хууль бол өргөн баригдсан байгаа. Гэхдээ би энэ хуулийг мөн татаж авах гэж байгаа. Яагаад татаж авах гэж байна вэ гэхээр 3 сард хаврын чуулган эхлэхээс өмнө өргөн барих шаардлага байна. Энэ арилжааны хуулийг яг Улсын Их Хуралд өргөн барьдаг өдөр нь Монгол Улсын дээд шүүх санал өгсөн юм байна. Тэгээд Дээд шүүхийн саналыг тусгаагүй өргөн барьчихаж. Дээд шүүхийн ирсэн саналыг аваад үзэхээр ер нь зарчмын шинжтэй, шууд хэлэлцүүлэгт оруулахад бэлэн биш ийм санал өгсөн. Би энэ саналыг уншиж үзэж байхдаа мэдэхгүй Монгол Улсын дээд шүүх хэзээ ч ийм үгнүүдийг хэрэглэж байгаагүй байх гэмээр тийм ноцтой үгнүүдийг хэрэглэсэн. Нэн аюултай, энэ асуудал бол асар болгоомжтой хандах ёстой. Энийг хатуу анхааруулж байна гэсэн ийм санал өгсөн байна. Өөрөөр хэлбэл энэ өөрөө тогтолцооны шинжтэй. Хууль хэрэглээн дээр дэм болохоосоо дэгээ болчих вий гэдэг ийм болгоомжлолыг нэлээн сануулсан. Тэр дотроо Иргэний хуулиасаа томоохон хэмжээний бүлгийг шууд сугалж аваад, бие даасан хуулийн хэлбэрээр бичээд, энэ нь өөрөө Иргэнийхээ хуулийн бидний бол Үндсэн хууль шүү

дээ энэ чинь. Нөгөө Үндсэн хуулийнхаа суурь зарчим руу доголдол үүсгэхийг вий гэдэг ийм сануулгыг Улсын дээд шүүх өгсөн. Тийм учраас Улсын дээд шүүхтэй энэ асуудлаар саналыг нь сайн ярилцах хүрээнд татаж авч, Улсын Их Хуралд өргөн барихгүй бол яг хууль тогтоох байгууллага дээр энэ асуудал хэлэлцэгдэхээр Улсын дээд шүүхийн саналыг хууль тогтоогчид маань энд ярилцана гэвэл бас нэлээн цаг хугацаа, нэлээн асуудал үүсэхээр ийм байгаа учраас та бүхний ажлыг бас хөнгөвчилж/минут дуусав/

Д.Цогтбаатар: Цэнгүүн гишүүний микрофоныг өгье.

С.Цэнгүүн: Оройн мэнд хүргэе Хууль зүйн байнгын хорооны гишүүддээ. Тэгээд та бүхэнд бас мэдээллийн чанартай юм хэлэх гэсэн юм. 2024 оны 10 сард Ардчилсан намын бүлгээс Эдийн засгийн эрх чөлөө, бизнес эрхлэхтэй холбоотойгоор хэлэлцүүлэг зохион байгуулаад, тухайн үед 10 сард бол Ардчилсан намын бүлэг дээр энэ ер компани нээж болдог, тэгээд татан буулгаж болдоггүй, дампууруулж болдоггүй энэ харилцааг шийдвэрлэж өгөхгүй юм бол манай энэ doing business index энэ тэр чинь ерөөсөө сайжрахгүй юм байна гэдэг агуулгаар манай бүлэг дээр бол ажлын хэсэг гарсан. Тэгээд энэ ажлын хэсэг дээр бол 6 гишүүн, 7 гишүүн орж ажиллаад, миний бие бол ахлагчаар ажиллаад явсан байгаа юм.

Тэгээд 4 сарын 1-нд бол бид нар ажлын хэсгийнхээ санал, дүгнэлтийг гаргаад, энэ хугацаанд бол Хууль зүйн яаман дээр бас яг энэ төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн ажлын хэсэг бол байгуулагдсан байдаг. Тэрний дараагаар 5 сарын 27-нд бол энэ хууль маань өргөн баригдсан буюу ажлын хэсэг дундаа 1 л удаа уулзаж амжсан. Тухайн үедээ бол тал талдаа асуудлууд байгаа юм байна. Бид нар энэ 1997 оны Дампуурлын тухай хуулийн харилцааг сайжруулах шаардлагатай юм байна гэдэг дүгнэлтэд хүрээд гэтэл нөгөө сайжруулах саналуудаа оруулж амжаагүй, төсөл дээрээ ажиллаж чадаагүй байж байтал энэ төсөл маань өргөн баригдчихсан гэсэн үг. Тэгээд харахаар одоо юу болж байна гэхээр энэ 60 хуудас төсөл дээр бол нэлээн олон нэр томъёоны зөрүүтэй асуудлууд байгаад байгаа юм. Дээрээс нь дагалдах хуулиуд дээр бас маргаантай. Одоо нөгөө бөөсийг нь түүнэ гэж ярьдаг. Тэр зүйлүүдээ хийгээгүйгээр зүйл, заалтууд нь зөрчсөн ч байдаг юм уу тийм маш олон ажилбарууд хийгдэх шаардлагатай. Тэгээд концепцын хувьд хамгийн том хүндрэлтэй байгаа зүйл нь болохоороо ер нь бол ажлын хэсгийн дүгнэлт дээр энэ төсөл маань уг нь бол Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль дээр байгаа одоогийн энэ баримт бичиг дээр бол хугацааны шалгуур, тоон босго дээр төвлөрсөн зохицуулалт давамгайлж байгаа гэдэг агуулгаар явчихсан байгаад байгаа юм. Гэтэл үндсэндээ бол бид нар мөнгөн урсгал, бизнесийн ирээдүйн чадамж дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг сэргээх боломж байгаа эсэх буюу эдийн засгийн бодит үнэлгээний асуудал дээр нь төвлөрч энэ хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байтал үндсэн концепцоороо энэ маань өөрөө дутуу явчихсан байна гэж хараад байгаа.

Тэгээд сая Алтанхуяг гишүүн бас хэлж байна. Төлбөрийн чадваргүйдлийг тодорхойлох маань өөрөө энэ Дампуурлын тухай хуулийн процессын 1 хэсэг нь байгаад байгаа юм. Тэгэхээр нөгөө нэг төлбөрийн чадваргүйдлийг нь бид нар тодорхойлсон. Тэрний дараагаар тухайн компанийн үйл ажиллагааг зогсоогоод, улсын бүртгэлээс хасах хүртэлх үйл процесс нь бид нар сая бас салбарын сайд нь хэлж байна. Татварын албатай ярих ёстой. Улсын бүртгэлийнхэнтэй ярих ёстой. Энэ харилцаанууд нь өөрөө зохицуулагдаагүй байгаа учраас энэ бол маш цаг үед шаардлагатай чухал хууль уу. Маш чухал хууль. Хэлэлцүүлэгдээд явах шаардлагатай. Гэхдээ гол нь бид нар яг энэ том том зарчмын зөрүүтэй, дээрээс нь

маш их ажилбаруудыг шинэчилсэн найруулгын хүрээнд ажлын хэсэг дээр хийж чадах болов уу гэдэг дээр бас асуумаар байна. Хэрвээ бид нар нэгэнтээ энэ том суурь өөрчлөлтийг хийх гэж байгаа бол нэлээн сайн харж байгаад шинээр ахиад өргөн баривал дээр биш үү. Яагаад гэвэл саналууд нь .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээгээд өгье.

С.Цэнгүүн: Ажлын хэсэг дээр бол саналуудаа тусгасан байсан. Гэхдээ зүгээр шинэчилж амжаагүй байсан ийм асуудал байгаа юм. Тэгэхээр энийгээ татаж авч байгаад, ахиад төслөө сайжруулаад оруулаад ирвэл ямар вэ гэдэг ийм санал бас байна. Тэгээд энэ дагалдах хуулиуд дээр ч гэсэн бид нар харах ёстой. Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн энэ саналын томъёог нь бас гишүүд маань харах юм бол жишээ нь Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирсэн саналууд бол тусгагдаагүй. Бусад гишүүд буюу надаас очсон саналуудыг тусгасан гэж хэлсэн хэр нь тусгагдаагүй байдлаар бол ороод ирчихсэн. Ямар ч ажилбар хийхгүйгээр эхний драфтаар ороод ирчихсэн байгаад байгаа юм л даа. Тэгэхээр бид бүхэн энэ дээр нэлээн сайн анхаарах хэрэгтэй юм болов уу гэж бас хараад байна.

Д.Цогтбаатар: Энэ дээр Хууль зүйн сайд. Хууль зүйн сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Цэнгүүн гишүүнд баярлалаа. Тэгээд энэ асуудлыг бас би Цэнгүүн гишүүний ярьж байсан зүйлүүдийг бас харж байсан. Яг энэ асуудлыг бас тухайлж, тэр дотроо одоо Ардчилсан нам ч гэсэн бас Өршөөлийн хууль яриад байна лээ шүү дээ. Өршөөчихье. Нийгмийн даатгал, татварын өршөөл гаргачихъя. Энэ их нухацтай ярих ёстой асуудал юм байна лээ. Яагаад гэхээр бид нар 1997 оны энэ дампуурлын хүчээр дампууруулдаг юмны 2 талтай байгаад байгаа. Ерөөсөө юм 2 талтай. Түрүүн би хэллээ шүү дээ. Зарим хүмүүс бол манай Мөнх-Эрдэнэ дэд сайд түрүүн сая тодорхой статистик хэллээ. Шүүхээр явж байгаа хэрэг дээр бараг энэ 90 орчим хувь нь тэр дампуурах гэж байгаа этгээд өөрөө хүсэж, шүүхэд хандаж дампуураад байна гээд. Үүний цаана судлах юм бол энэ чинь зохиомлоор дампуурах, татвараас зайлсхийх, үүрэг, хариуцлагаас чөлөөлөгдөх ийм санаатай үйлдлүүд яваад байна. Ялангуяа энэ нөгөө гол ус бохирдуулдаг алтны компаниуд дээр энэ их ажиглагдсан. Лицензтэй компаниуд дээр. Алтыг нь ухаад, байгаль орчин сүйтгээд, нөхөн сэргээлтийг нь хийх үүргээсээ чөлөөлөгдөхийн тулд компаниа дампууруулаад, тэгээд яваад байдаг. Тэгээд ийм асуудлууд өөрөөр хэлбэл энэ хуулийн хийдлийн нөгөө талд нь гарч ирээд байгаа юм. Тийм учраас ийм шинжтэй үйлийг өөгшүүлж болохгүй. Өөгшүүлж болохгүйн цаана Өршөөлийн хууль гаргачихъя гэдэг үг, үйлдлүүдийг их болгоомжтой хэрэглэх ёстой юм байна лээ. Ингэнгүүт 5 жилийн дараа Өршөөлийн хууль гарчих юм чинь гэдгээр нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй байдаг. Эндээс хэн хохирдог вэ гэхээр тэнд ажилласан олон мянган ажилчид, цаашдаа өвдөж ч болохгүй, үхэж ч болохгүй, тэтгэвэрт гарч ч болохгүй хохирдог ийм асуудал гардаг. Татвар дээр мөн татварын өршөөлийн асуудал ингээд өршөөчихье гэнгүүт нөгөө талд нь татвараа төлөхөөс зайлсхийх ийм санаатай, болгоомжгүй бас үйлдлүүд гардаг.

Тийм учраас би саяын хэлж байгаа татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй санаатай байг гэж хэлнэ үү, эсвэл ийм нөхцөл байдал гэж хэлнэ үү ийм шинжтэй захиргааны шинжтэй гэж яриад байгаа юм. Татварын байгууллага оролцдог, бүртгэлийн байгууллага оролцдог ийм шинжтэй асуудал тусдаа бие даасан хуулиар зохицуулагдах хэрэгцээ шаардлага байгаа юм биш байгаа даа гэж. Энэ дээр би тантай санал нэг байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр дээр одоо

би Хууль зүйн сайдын хувьд иж бүрэн судалгаа хийгээд, яг ийм нэртэй, ийм хууль би өргөн барья гэсэн бодолтой байгаа гэж би одоогоор хараахан тэгж хэлэхээр хэмжээнд Улсын Их Хурал дээр итгэлтэйгээр хэлэхээр хэмжээнд би бэлэн биш байгаад байгаа юм.

Тийм учраас одоо байгаа хэмжээнд бол би бие даасан харилцаагаар зохицуулах шаардлага байгаа юм биш байгаа даа гэж 1 дүгээрт харж байгаа юм.

2 дугаарт, Засаг дээр буцаагаад орж ирэхээр энийг Сангийн яам, татварын байгууллага би түрүүн хэлээд байгаа энэ үзэл баримтлал баталдаг, тэгээд Засгийн газраас орж ирж байгаа хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барих мөн зөвшөөрөл өгдөг яам байхгүй юу. Тэгэхээр би шуудхан хэлэхэд дахиад энийг оруулж ирэхээр зарим зүйлүүдийг нь бас буулт хийгээд Их Хуралдаа өргөн барьдаг ийм практик бол бас байна. Өөрийнхөө хүссэн хэмжээнд биш. Тийм ээ. Буулт хийгээд тэр талын. Энийг хууль тогтоогч уг нь эндээ ажлын хэсгийн түвшинд шинэчилсэн найруулга учраас нэмж ч болно, хасчхаж болно, өөрчлөн найруулж ч болно. Энэ дээр бол Засгийн газар, тэр дотроо Хууль зүй, дотоод хэргийн яамны хамт олон та бүхэнтэйгээ хамтраад, дэмжээд, хамтарч ажиллахад бэлэн байна.

Д.Цогтбаатар: Цэнгүүн гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

С.Цэнгүүн: Энхбаяр сайд бид 2 сая ойлголцсонгүй юу яасан. Би энэ хуулийг маш их дэмжээд байгаа хүн байхгүй юу. Тэгээд маш сайн, зөв процесстойгоор энэ нөгөө процесс өөрөө тодорхой байх ёстой л байгаад байгаа юм. Амархан байх ёсгүй. Энэ чинь тодорхой ойлгомжтой хэрэгждэг байх ёстой. Тэр утгаар нь бид нар нөгөө хуулиа анхнаасаа боловсруулахдаа алдаа мадагтай зүйл хийчхэж болохгүй. Тэр агуулгаар нь ажлын хэсэг дээрээ үнэхээр бид нар сайн ажиллаад, тэр алдаануудыг засах боломж нь яг байгаа юм уу гэдэг талаас нь ахиад хараад үзвэл яасан юм бэ. Тэгээд миний зүгээс харахаар энэ дээр чинь маш их деталь болон дээрээс нь концепцын хувьд, нэр томъёоны хувьд ч тэр нөгөө санал зөрөлдөөнтэй асуудлууд байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр асуудлуудаа бид нар ажлын хэсэг дээрээ шийдэх боломж нь байгаа юм уу гэдэг процессын тухай асуудлыг л би асууж байна л даа. Нэрээсээ авхуулаад/минут дуусав/

Д.Цогтбаатар: Энхбаяр сайд гүйцээгээд хариулах уу.

Б.Энхбаяр: Шинэчилсэн найруулгын хувьд бол Хууль тогтоомжийн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын гишүүд хуулийн нэр, гарчгаас эхлүүлээд бүх зүйл дээр санал гаргаж, өөрчлөн найруулах бүрэн эрх, боломж нь бол шинэчилсэн найруулгын тухайд бол бүрэн байгаа. Тийм учраас Цэнгүүн гишүүн та бас ажлын хэсэгт орж ажиллаасай гэж бодож байна. Энэ чинь болдог биз дээ. Тэгвэл бас Цэнгэн гишүүнийг бас оруулаад, тэгээд ажлын хэсэг байгуулаад, саналыг нь аваад явбал их зүгээр байна л гэж би хэлмээр байна.

Д.Цогтбаатар: Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

Ц.Сандаг-Очир: 1 дэх асуудал бол би тоо баримт асууя. Өнгөрсөн хугацаанд Дампуурлын тухай хуулиар ер нь хэчнээн компани, аж ахуйн нэгж яг шүүхийн шийдвэрээр дампуурлаа, тогтоогдлоо, хохирол юм нь яав гэдэгтэй холбоотой тоо баримтуудыг хэлж өгөөч. Тэндээс юу харагдах вэ гэхээр энэ хууль бас нийгэмд үнэхээр хэрэгцээтэй, шаардлагатай байгаа юм байна. Зохицуулах шаардлагатай байгаа юм байна. Бас хуучирсан зүйл, заалтууд нийгмийн харилцааны сүүлийн

үеийн шинэ харилцаануудыг зохицуулж чадахгүй байгаа юм байна гэдэг нь тэндээс бас харагдах байх гэж ингэж бодож байна.

2-т хуулийн үзэл баримтлал бол дампуурсан хойно нь биш дампуурахаас нь өмнө аж ахуйн нэгж, компаниудад урьдчилан улаан гэрэл асахаас нь өмнө танайх дампуурах гээд байна шүү гэдэг зөвлөгөө өгөх, эргээд бизнес үйл ажиллагааг нь тогтвортой байлгах, босгох, сэргэх энэ бололцоо боломжийг нь олгох тал руугаа философи нь байгаа юм байна гэж ингэж ойлголоо. Тэгвэл тэр дампуурах гээд байна гэдгийг өнөөдөр залуучууд яаж байна бизнес эрхлээд явж байна. Аминдаа л ашиг орлого олох гээд, бизнес үйл ажиллагаагаа өргөжүүлэх гээд ингээд л арилжааны гэрээ, хэлцэл хийгээд, амьдрал ахуйгаа дээшлүүлэх гээд л явж байгаа юм. Мачийгаад байдаг, мачийгаад байдаг. Нэг мэдэхэд л улам дордчихсон, дампуурах дөхчихсөн, үр дүн гардаггүй ийм байдал руу л ордог. Тэгвэл хуулийн үзэл баримтлалтай холбогдуулаад энэ ер нь асуудал хүндэрчихсэн байна, дампуурах байдал руу орчихсон байна гэдгийг хэн тогтоох юм бэ. Тухайн компани өөрөө энийгээ дүгнэх юм уу, эсвэл өөр бусад хуулийн этгээд энийг нь тогтоох юм уу, эсвэл тэрийг нь тогтоодог тийм бас 1 хуулийн этгээд тусдаа байх юм уу. Энэ зөвлөгөө юмыг нь хэн өгөх юм бэ. Хуулийн төсөлд яаж туссан юм бэ. Энэ бол та нарын үзэл баримтлал чинь бол нөгөө өвдөхөөс нь өмнө, өвдчихсөн хойно нь биш өвдөхөөс нь урьдчилан сэргийлэх хууль гээд байна шүү дээ. Тэрэнтэй адилхан тэгвэл өвдөхөөс нь урьдчилан сэргийлэхэд Нийгмийн эрүүл мэндийн зөвлөл урьдчилан сэргийлэх зөвлөгөөг өгдөг. Тэгвэл энэ хууль дээр дампуурахаас нь өмнө хэн зөвлөгөө өгөх юм. Хэнд хандах юм. Би ингээд хүнд байдалд орчихлоо. Эрсдэлд орчихлоо, өр авлагад орчихлоо. Хаана хандах вэ. Иргэний эрх зүйгээр бол энэ чинь нөгөө эвлэрүүлэн зуучлах үйлчилгээг авах гээд байна шүү дээ. Шууд гэр бүл салмааргүй байна. Урьдчилаад бас нэг ярилцаж үзмээр байна. Зөвлөгөө авмаар байна. Бас салахгүйгээр нийлчхэж болох бололцоо, боломж байхыг үгүйсгэхгүй..../минут дуусав/

Д.Цогтбаатар: Гүйцээх үү Сандаг-Очир гишүүн ээ. Ажлын хэсгээс хариулъя. Индэр дээр хэн нь гарах вэ. Индэрийн микрофоныг өгье.

О.Оюунзул: Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн дарга Оюунзул. Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Энэ Дампуурлын тухай 1997 оны хууль маань илүү дампуурлын зарчмуудыг тусгасан боловч процесс маш дутмаг. Энэ байдлаасаа болоод түрүүнд бас хэлсэн балансад тусгагдсан өөрийн хөрөнгийн 10 хувьтай тэнцүү ийм өр төлбөртэй байх юм. Дампуурлын хэрэг үүсгүүлэхээр хандаад байгаа. Тэгэхээр тухайн тэр компани баланс нь ямар байгаа юм. Өр төлбөр нь ямар байгаа юм гэдгийг нь нэхэмжлэгч нар, зээлдүүлэгч нар, хөрөнгө оруулагч нар мэдэх боломжгүйгээс болоод сүүлийн жилүүдийн статистикийг авах юм бол ихэнх хүсэлтийг өөрөө хариуцагч тэр үүрэг гүйцэтгэгч л гаргаж байгаа буюу нэхэмжлэгчид нийт 10 жилийн дунджаар 39 хэргээс зөвхөн 5 тохиолдолд нь л нэхэмжлэгч нар бол нэхэмжлэл гаргасан. Бусад тохиолдолд бол хариуцагч нар гаргасан байдаг. Тэгэхээр эндээс юу харагдаж байна гэхээр аль уже хөрөнгө орлого нь бол шилжчихсэн байдаг. Энэ хуулийн төслөөр бол аль болох төлбөрийн чадваргүй байдлыг нь эртхэн мэдэх буюу тухайн этгээд маань 3 болон түүнээс дээш удаа гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй болох юм бол тэрийг нэхэмжлэгчид шууд илэрхий мэднэ. Ингээд төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа үүсгүүлэх энэ нэхэмжлэлээ шүүхэд гаргаад, ингээд хэрэг үүсгүүлээд, илүү процессжуулсан байгаа. Энэ хүрээнд илүү мэдэж байна гэдэг чинь хөрөнгө орлоготой байгаа дээр нь тэр хуулийн этгээдийг нь дахин хөрөнгөжүүлж зохион байгуулах юм уу, эсвэл үнэхээр татан буулгаад нэхэмжлэгчдийн эрхийг тэгш

хангуулаад, байгаа хөрөнгийг нь хуваарилах юм уу. Энэ процессыг нь л энэ хуулийн төслөөр тодорхой болгосон. Хуулийн төсөл маань бол 156 зүйлтэй байгаа. Дампуурлын хууль бол 37 зүйлтэй. Тэгээд энэ маань бол олон улсдаа Төлбөрийн чадваргүйдлийн энэ хуулиуд маань бол жишээ нь Германд төлбөрийн чадваргүйдлийн хууль нь 330 зүйлтэй, Солонгос улсад 660 зүйлтэй байдаг. Орост гэхэд анх 58 зүйлтэй ийм хуультай байж байгаад бас л манайх шиг зөвхөн хариуцагч тэр хуулийн этгээд л өөрөө мэдэх боломжтой болохоор маш бага хэмжээний нэхэмжлэлүүд гарч байсан. Тэгээд 1998 онд дахиж хуулиа шинэчлээд, 150 зүйлтэй болгоод процессжуулаад өөрөө хөрөнгө орлого, төлбөрийн чадваргүй болсныг нь нэхэмжлэгч нар мэдэх боломжтой байдлаар тусгаж өгснөөр 200 мянга орчим нэхэмжлэл гараад, энэ хууль маань хэрэгжээд маш сайн явсан байдаг. Тэгэхээр манай хуулийн төсөл бол илүү Германы хуультай бас олон улсыг нь судалж ингэж процессжуулж өгсөн байгаа.

Тэгээд хамгийн гол чухал зүйл нь хөрөнгө орлогогүй болохоос нь өмнө мэдэж тэр хөрөнгө орлогыг нь үндэслээд амилуулах уу, аврах уу. Эсвэл нэхэмжлэгчдийн байгаа нийтэд ил тод, сайн мэдээлж нэхэмжлэгчид хүртээмжтэй тэгшээр байгаа хөрөнгийг нь хуваарилж татан буулгах уу гэсэн энэ асуудлыг бол зохицуулж байгаа юм.

Д.Цогтбаатар: Ганбат гишүүний микрофоныг өгье. Ганбат гишүүн байна уу. Ганбат гишүүн алга байна. Соронзонболд гишүүн. Энэ асуудал маш чухал, бизнес эрх зүйн салбарын суурь асуудал хэлэлцэж байгаа учраас энэ удаа Соронзонболд гишүүнд микрофон өгье. Ер нь бол хэдүүлээ дэгээ барьж ажиллана шүү. Тэр хугацаа олгогдсон үедээ л саналаа өгөх ёстой. Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

Л.Соронзонболд: Хууль зүйн байнгын хороо дээр энэ маш чухал ийм хуулийн нэмэлт найруулга орж ирж байгаа юм байна. Энэ төлбөрийн чадваргүйдэл дээр яах вэ 3 нөхцөл хангасан тохиолдолд эхлүүлэх тухай тусгагдсан байна л даа. Тэгээд ингээд бодоод үзэхээр нөгөө өөрийн хөрөнгийн 30 хувь гэдэг чинь бол жишээлбэл компанийн балансын хэмжээ хэд ч байж болно шүү дээ. Өөрийн хөрөнгийн хэмжээ. Тэгэхээр 30 хувь гээд. Хэдэн төгрөгийн асуудал ярьж байна вэ. 5 сая төгрөгийн өөрийн хөрөнгөтэй компани байвал сая 500 мянган төгрөгийн өр дээр ингээд төлбөрийн чадваргүйдлийн асуудлыг үүсгэх үү гээд л асуулт байна.

2-т болохоор ер нь яах вэ, арилжааны банкнууд ч тэр, банк бусууд чинь бас өөрсдөө нөгөө зээлийнхээ гэрээний үүргээ биелүүлэхгүй байгаа асуудал дээр 90 хоногийн интервалтай яваад, 365 хоног явсны дараагаар нөгөө зээл муу болоод, тэгээд тэр чинь шүүх рүү явж байгаа шүү дээ. Одоо энэ хуулийн төслийг уншихаар ерөнхийдөө 90 хоног гэрээний үүргээ биелүүлэхгүй байвал төлбөрийн чадваргүйдлийн асуудлыг эхлүүлж байна гэж би харж байна. Тэгэхээр яг энэ төслийн дэлгэрэнгүй танилцуулга дээр болохоор бол ер нь үүргээ биелүүлэхгүй 6 сар гээд, нийт хөрөнгийн 50 хувь гэхихсэн байсан байхгүй юу. Гэтэл одоо яг хуулийн төсөл дээр болохоор үүргээ биелүүлэхгүй 3 сар болоод, өөрийн хөрөнгийнх нь 30 хувиас хэрвээ өр төлбөр нь хэтрэх юм бол төлбөрийн чадваргүйдэл рүү явах гэж байна гэсэн иймэрхүү утга орж ирээд байна л даа. Тэгэхээр яагаад ийм ялгаатай байгаа вэ гээд. Яах вэ, энэ 3 сар гэдэг санаа нь болохоор бол одоо яг бодит амьдрал дээр бөөний компаниуд жижиглэн худалдаа эрхлэгч ч юм уу, дэлгүүрүүдэд бараагаа нийлүүлдэг байхгүй юу. Тэгээд сар дотроо ч юм уу тооцоогоо хийгээд явдаг. Тэгэхээр тэр компаниудад зориулж ингэж 3 сар гэж тусгаад байна уу. Эсвэл ерөнхийд нь яг цаад шинэчилсэн найруулгын гол зорилгынхоо хүрээнд ингэж 3 сар

гэдэг асуудал тавиад байна уу гэдэг дээр тодруулах асуулт байгаад байгаа юм. Энийг 1 дүгээрт эхлээд асуучихъя.

Д.Цогтбаатар: Ажлын хэсгээс хэн хариулах вэ. Оюунзул уу, Мөнх-Эрдэнэ үү. Оюунзул. Оюунзул даргын микрофоныг өгье. Индрийн микрофон.

О.Оюунзул: Хуулийн төслөөр бол үүргээ гүйцэтгээгүй 3 сар болох юм дампуурлын төлбөрийн чадваргүйдлийн ажиллагаа эхлүүлэхээр хүсэлт гаргахаар бол төлбөрийн чадваргүйд тооцох бас үндэслэл болохоор ингэж тусгаж байгаа. Энэ дээр бол нөгөө олон улсдаа бэлэн мөнгөний арга гээд байгаа. Бас дахиад балансын арга гэж байдаг. Балансын арга нь болохоороо түрүүнд хэлсэн. Баланс дээр байгаа нийт хөрөнгөд эзлэх өр төлбөр нь 10 юм уу, 30 хувьтай тэнцүү байх юм бол гэхээр нөгөө нэхэмжлэгчид маань мэдэхгүй байгаа. Манай дампуурлын хууль бол яг энүүгээр явж байгаа. Тэгэхээр улсууд нэг бол энэ бэлэн мөнгөний аргаар буюу үүргээ гүйцэтгэж чадаагүй тохиолдолд, эсвэл балансын аргаар буюу баланст эзлэх хөрөнгө, өр төлбөр нь ямар байгаа юм бэ гэдэгт үндэслээд, аль эсвэл хосолмол байдлаар энэ төлбөрийн чадваргүйд тооцох үндэслэлийг бол тогтоож өгсөн байдаг. Тэгээд бид хэд бол хуулийн төслөөрөө аль болох нэхэмжлэгч нар оройтохоос нь өмнө, хөрөнгө орлогоо нааш цааш нь болгохоос нь өмнө мэдүүлэх зорилгоор энэ бэлэн мөнгөний арга буюу үүргээ гүйцэтгээгүй 3 сар болсон бол гэдэг юуг бол ажлын хэсгийн зүгээс олон улсын судалгааг үндэслээд 3 сар гэдэг зүйлийг тавьсан.

Өөрийн хөрөнгийн 50 хувьтай тэнцэх хэмжээний өр төлбөртэй гэж бол анхны хуулийн төсөлд байсан. Улсын дээд шүүхээс санал ирсний үндсэн дээр энэ 50 хувь гэхээр арай илүү оройтчих гээд байна. Энийг жаахан наашлуулъя гэдэг үндэслэлээр бид хэд 30 хувь, өөрийн хөрөнгийн 30 хувьтай тэнцүү болгож буулгасан байгаад байгаа.

Мөнгөн дүнгийн бол хязгаар байхгүй л байгаад байгаа. Бүр ингээд төлбөрийн чадваргүй, зардлаа ч төлөх боломжгүй хөрөнгө орлогоо шилжүүлчихсэн ийм компаниудын хувьд бол энэ хуулийн төслөөр бол ажиллагаа явагдахгүй. Энэ хуулийн төсөл бол тодорхой хэмжээний орлоготой, эртхэн мэдээд ингээд аврах эсвэл татан буулгах нэхэмжлэгчийн эрх ашгийг хангах тал руугаа явагдаж байгаа. Харин үнэхээр зүгээр карманы шинжтэй болчихсон тийм компани байх юм бол нөгөө санхүүгийн тайлангаа өгөөгүй тэр чиглэлийн хуулийн этгээдийн улсын бүртгэлээрээ бүртгэлээс хасагдаад явна. Энэ бол шүүх оролцох шаардлагагүй ийм харилцаа байгаад байгаа. Тэгээд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатад бас манай энэ Дампуурлын хууль яг ингэж үйлчилж ирсэн болохоор ихэвчлэн нөгөө татварын өртэй, нийгмийн даатгалын өртэй, ихэнх нь хөрөнгө орлогогүй болчихсон ийм компаниуд дээр дампуурлын хэрэг үүсгээд ингээд явдаг. Эцэстээ бол ер нь татварын өрнөөсөө зайлсхийх л арга болж ирсэн байгаад байдаг. Тэгэхээр шүүхийн шийдвэр шатанд байгаа, нэгэнтээ шийдвэр гараад, өр төлбөртэй төлбөр төлөгч компаниудын хувьд бол одоо энэ хуулийн төсөл батлагдсанаар бас багасах, буурах, илүү нөгөө хөрөнгө орлогоо нааш цааш нь шилжүүлэхээс өмнө мэдэх, дахиад дараа дараагийн компаниуд мэдэхгүйгээр гэрээ байгуулж хохирох энэ нөгөө шүүхийн шийдвэр дээр бас ингээд ажиллагаатай байгаа хөрөнгө орлогогүй энэ хуулийн этгээдийн тоо бол буурахад маш их эерэг нөлөө үзүүлэх юм.

Д.Цогтбаатар: Тодруулъя. Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

Л.Соронзонболд: Төлбөрийн чадваргүйдлийн энэ балансаар ингээд өөрийн хөрөнгийнх нь 30 хувиас ч юм уу, нийт хөрөнгийн 50 хувиас хэтэрсэн бол гэдэг чинь

өөрөө явсаар байгаад арилжааны банкнууд юм уу, банк бус санхүүгийн байгууллагууд ч юм уу, тэр тухайн компани, бизнес эрхэлж байгаа хүмүүст өгч байгаа зээлийн хэмжээ дээр очиж нөлөөлнө. Тийм учраас бол би энэ хэмжээ дээр бол нэлээн сайн анхааралтай хандахгүй бол энэ хууль батлагдсантай холбоотойгоор компаниудад олгодог арилжааны банкнуудын зээлийн хэмжээ буурах ч гэдэг юм уу тийм бас эрсдэл байж болзошгүй. Тийм учраас энэ дээр бол нэлээн сайн анхаарах ёстой болов уу л гэж бодоод байна.

Тэгээд ерөнхийдөө болохоор яг нөгөө хэмжээг нь тодорхой заахгүй болохоор чинь 3 сар гэдэг ер нь бол бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүсийн хувьд бол маш богино хугацаа. Тийм учраас тэр 3 сарын дараа шууд ингээд төлбөрийн чадваргүйдэл руу хүсэлт гаргагч нь зөвхөн нөгөө татвар, нийгмийн даатгалын чиглэлийн өртэй холбоотойгоор бодож ингээд тавьчихсан юу чинь явсаар байгаад зүгээр ингээд явж байгаа бизнесийн үйл ажиллагаануудад нөлөөлөх вий гэдэг нэг ийм болгоомжлол байгаад байна. Тийм учраас .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Соронзонболд гишүүний хөндөж байгаа асуудлыг бас Улсын Их Хурлын ажлын хэсгийн түвшинд олон талаас нь бас ярилцах боломж гарах байх. Ажлын хэсэг дээр бол би бас нэг зүйлийг өнөөдрийн хэлэлцүүлэг дээр бол яг энэ 10 жил нөгөө судалгаа гэж бас явсан хуулийн төсөл гэдгийг түрүүн би хэлсэн. Энэ хуулийн 10 жилийн өмнөхөөс нь эхлээд өнөөдрийг хүртэлх оролцсон маш олон хүн байгаа. Судлаачид хүмүүс. Энэ өнөөдрийн хэлэлцэх эсэх асуудал дээр бас бүгд байх боломж бас бүрдсэнгүй. Янз бүрийн ажил албан тушаалтай хүмүүс байгаад. Тэгээд яагаад юм яг өнөөдөр би уг нь бүгдийг нь л авчирчих гээд үзлээ. Тэгээд бүгд яг хурал ном нь давхцаад, тэгээд ийм асуудал гарсан. Тэгээд Их Хурлын ажлын хэсэг дээр та бас асуудлыг олон талаас нь хэлэлцэх боломж бас бүрдэх байх гэж үзэж байна.

Д.Цогтбаатар: Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр энэ төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийг дэмжиж байгаа. Тэгэхдээ бас тодорхой хэмжээгээр энэ 2 талын харилцагч буюу тодорхой хэмжээгээр хадгаламж хуримтлуулаад, түрүүгээрээ зээл олгож байгаа банкнуудын асуудал бас нөгөө талаасаа яригдах ёстой. Тэгэхээр би нэг зүйлийг хэлье л дээ. Тэгэхээр одоогийн байдлаар Монголд бол энэ банкнууд зээл өгөөд, зээлээ шийдвэрлэх хугацаа нь бол дунджаар 4,7 жил болчихоод байгаа юм. 4,7 жил гэдэг бол маш урт хугацаа. Энэ дээр нь ажилладаг бүр тэр үнэлгээчин, өмгөөлөгч гээд удаашруулдаг бүр бүлэг хүмүүс гарчихсан. Энийг нь удаашруулаад л байж байдаг. Хэрвээ бага хэмжээний зээлийг 6 сарын дотор, дундаж хэмжээний зээлийг 8 сарын дотор, их хэмжээний зээлийг 1 жилийн дотор хэрвээ шийдчих юм бол зээлийн хүүг даруу 4,2 хувиар буулгах ийм боломж банкнуудад байгаад байгаа юм. Тэгэхээр ер нь дэлхий даяар бол commercial court ч юм уу аль эсвэл financial court ч юм уу ийм бизнесийн шүүхүүд, санхүүгийн шүүхүүд бол байдаг ийм жишиг байгаа.

Тэгэхээр яг тусгайлан жишээ нь энэ банкнуудын болон банк бус санхүү болон бусад байгууллагуудын зээлийг маш хурдан хугацаанд шийддэг. Тэгээд түүгээрээ бас тодорхой хэмжээний шимтгэлээрээ үйл ажиллагаагаа явуулдаг ийм тогтолцоо бол дэлхийн нэлээн олон орнуудад байдаг. Тэгэхээр Англид бол энэ бүр тодорхой бүр financial court гээд ингээд байж байдаг. Тэгэхээр энэ шүүхийг байгуулах ийм боломж байгаа юу. Хэрвээ ингэх юм бол энэ маргааны хурдан хугацаанд шийдсэний

үр дүнд бид нар нөгөө үндсэн бүх хэвийн явж байгаа аж ахуйн нэгжүүддээ зээлээ хугацаандаа аваад, хугацаандаа төлдөг тэр аж ахуйн нэгжүүдэд зээлийн хүүг нь 4,2 хувиар багасгаж өгөх ийм боломжууд байгаад байгаа байхгүй юу даа.

Тийм учраас энэ асуудал ер нь шийдэгдэх боломжтой юу. Тэгээд энэ дээр бас олон улсын практикийг мэдэхийн хувьд бол манай Цогтбаатар дарга нэг хариулт өгөөч. Энэ дээр ер нь цаашдаа ийм бодлого байгаа юу гэдэг дээр Энхбаяр сайд бас хариулт өгөөч гэж хүсэж байна.

Д.Цогтбаатар: Хууль санаачлагчаас асууна шүү дээ. Тэгэхдээ би энэ дээр бас өөрийн байр сууриа хэлнэ. Зүгээр үгээ хэлэхдээ түрүүн Энхбаяр сайд ер нь бол хариулчих энэ дээр. Гэхдээ та яг энэ асуултад нь бас хариулчих. Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Б.Энхбаяр: Пүрэвдорж гишүүн бас хоцроод ороод ирчих шиг боллоо. Түрүүн Сайнзориг гишүүн бас яг асуусан юм. Арилжааны шүүхийн асуудлыг асуусан. Арилжааны мэдээж хууль ямар хэмжээнд байх вэ гэдэг асуудалтай холбогдоно. Энэ Арилжааны хууль батлагдаад, яваад ийм дагнасан чиглэлтэй арилжааны шүүх байгуулагдах эсэхтэй холбоотой асуудал яригдана. Энэ нь цаашаа 5, 10 жилийн дараах бид нар гэх юм бол эн тэргүүн ээлжид юу хийж болохоор байна вэ гэхээр үнэхээр энэ зээлийн хүүг бууруулахад шүүхийн зардал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хугацаа удаашралтай байгаа нь зээлийн хүүгийн хувьд нөлөөлж байгааг бол ялангуяа банк санхүүгийн байгууллагынхан бол нотолгоотой ярьдаг. Би дөнгөж түрүүчийн 7 хоногт Монгол Улсын дээд шүүхийн шийдсэн 1 хэргийг хэлье.

300 сая төгрөгийг банк бус санхүүгийн байгууллагаас 8 жилийн өмнө авсан. Төлөөгүй. Ингээд 8 жилийн өмнө шүүхийн шийдвэр гарсан. 8 жилийн өмнө шүү. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдсан. Тэр 300 сая төгрөгийг авсан этгээд бол үл хөдлөх хөрөнгөтэй, тэрийгээ цааш нь бизнес болгочихсон, бүр том хэмжээний объектуудтай, хангалттай орлоготой байгаа гэдэг нь бол нотлогддог. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаа дээр бүх шатны шүүхээр гомдол гаргасаар байгаад 8 жил болчихсон. Энэ 8 жил шүүгдсэн үйл ажиллагаандаа тэр этгээд 80 мянган төгрөгийн зардал төлсөн байгаа. 80 мянган төгрөг төлөөд, 8 жил шүүхдээд 300 сая төгрөгийнхөө шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зогсоосон. Энд тэр тухайн 300 сая төгрөгийг зээлсэн банк бус санхүүгийн байгууллага ингэж хохирч байгаа гэсэн үг. Тийм учраас таны асууж байгаа зээлийн хүү өндөр байлгүй яах вэ. Ийм их зардал гаргаж байгаа юм чинь. Тэгэхээр яг ийм нөхцөл байдал байгаа учраас шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэх шаардлагатай байгаа. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулийг бол Алтангэрэл сайд 2025 оны 5 сард өргөн барьсан. Энийг сая хэлж байгаа энэ процесстой уялдуулаад би боловсронгуй болгоод, 2 сард буцаагаад өргөн барьчихъя гэж хэлж байгаа юм. Энэ дээр ямар тогтолцооны асуудал хөндөх гээд байна вэ гэхээр таны ярьж байгаа энийг ер нь ямар хэлбэрээр явуулах вэ гэдэг асуудал байгаа юм. Ямар цаг хугацаанд шилжүүлэх вэ гэсэн асуудал байгаа юм. Ер нь би бол төр, хувийн хэвшлийн холимог хэлбэртэйгээр 5 жил явж магадгүй гэдэг хувилбар оруулж ирж магадгүй. Холимог хэлбэрээр. Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тухайд ярьж байгаа шүү. Тогтолцоог нь би бол бүр бүрэн хэмжээнд ямар ч байсан хорих байгууллагын бүтцээс .../минут дуусав/

Д.Цогтбаатар: 1 минутыг гүйцээгээд өгье. Энхбаяр сайдад.

Б.Энхбаяр: Хорих байгууллагын бүтцээс иргэний шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг салгана гэсэн бодолтой байгаа. Хууль зүй, дотоод хэргийн сайд томилогдоод 30 хоногт бол 30-аад хүний халаа сэлгээ хийчихсэн байгаа. Энэ дотор иргэний шийдвэр гүйцэтгэлийн асуудал хариуцсан ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийг нь сольсон. 1 зарчим барьж байгаа. Хоригдлуудтай харьцаж байсан хүн ийм иргэний шийдвэр гүйцэтгэлийн асуудлыг би хариуцахгүй гэж үзэж байгаа. Шоронгийн дарга гэсэн үг. Энэ 2 тусдаа асуудал байгаа. Мөн цагдааг шоронгийн даргаар тавихгүй гэж байгаа. Мөн цагдааг шүүхийн шинжилгээний байгууллагад даргаар тавихгүй гэж байгаа. Өөрөөр бол бие биеэсээ хараат бус, бие даасан, мэргэжлийн байх онцлогтой ийм байгууллагуудыг бас байх ёстой байранд нь удирдлагын түвшинд бас манлайлж ажиллуулах ийм бодлогыг барьж байгаа. Энэ бодлогоо саяын ярьж байгаа шүүхийн шийдвэр/минут дуусав/

Д.Цогтбаатар: Би нэгтгээд, базаад саяын таны юун дээр би бас байр сууриа хэлнэ. Одоо хууль санаачлагчийн илтгэл, хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлага, хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоо болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Номинчимэг гишүүнээр, Соронзонболд гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүний микрофоныг өгье.

П.Сайнзориг: Баярлалаа. Хуулийн төслийг бол дэмжиж байна. Төлбөрийн чадваргүйдлийн хуулийг хэлэлцэхийг. Сая ингээд Пүрэвдорж гишүүн асуугаад, Энхбаяр сайд хариуллаа. Энэ Монгол Улсад арилжааны эрх зүй ямар хэмжээнд хөгжиж байгаа вэ гэдэг зүйлийг л илтгэж байгаа жишээнүүд байхгүй юу. Бид хэд арилжааны хуультай болсон эсэхээсээ үл хамаараад арилжааны шүүхтэй болох боломж нь байж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол Голланд улсад байдаг Маркит Горд, Солонгос бол дампуурлын шүүхтэй. Өөрөөр хэлэх юм be to be харилцаан дээр мэргэжлийн байх харилцаан дээр процесс нь өөр байдаг. Материаллаг хуулиудын зохицуулалтыг ч гэсэн илүү ялгамжтай хийж өгч болдог. Энэ мөнгө түгжигдэхгүй гэсэн үг. 80 мянган төгрөг төлчхөөд 8 жил шүүх дээр үүргийн гүйцэтгэлийг барина гэдэг чинь аймшигтай юм явж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид хэд энэ дээр илүү их be to be харилцаан дээр буюу арилжааны харилцаан дээр, бизнесийн харилцаан дээр ялгамжтай зохицуулалтуудыг хийх цаг нь болсон.

Тэгээд энэ дээр уг нь бол бас яах вэ, арилжааны шүүх, Арилжааны тухай хуулийг бие даасан байх уу, үгүй юу гэдгээс үл хамаараад энэ концепц яригдах ёстой юм гэдэг зүйлийг хэлмээр байгаа юм. Үүнээсээ уламжлаад аль болохоор төрийн тэр байгуулах арилжааны шүүх дээр бус, магадгүй тэр арбитр, эвлэрүүлэн зуучлал дээр илүү их мөнгөний хэргүүд зөв шийдэгдээд явах юм бол илүү нааштай болно. Тэгэхдээ өнөөдөртөө бид хэд арай жоохон мөнгөний болон гэрээний харилцаа, мөнгөний үнэ цэнийг ойлгодог тийм шүүхийн дадлага хандлагыг бий болгомоор байна. Манай шүүхийн л харилцаа шүү дээ. Яг үнэндээ хэлэхэд шүүх дээр ийм прогрессив жоохон юм ярихаар хэдэн хүмүүс ойлгодог, ихэнх нь айдаг. Тэгээд том том үг бичдэг. Тэгээд систем буюу эрх мэдлээсээ салдаггүй. Мөнгөний хэрэг өөрсөд дээр нь ирж шийдэгдэхийг л хүлээгээд байж байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм зүйлүүд байх юм. Тэгээд энэ Дампуурлын хуулийг бол бас их шийдэж байгаа нь тусдаа ийм арилжааны шүүхтэй болох асуудал зайлшгүй яригдана. Хэрэг гүйцэтгэгчдийг буюу бэлтгэх тогтолцоо. Энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэл бол биш шүү. Энэ бол цэвэр бизнесийн бараг захирлын хэмжээнд ажиллах чадвартай, шүүхтэй харилцах хувьцаа эзэмшигч буюу хөрөнгө оруулагчидтай харилцаж чадах, тэгээд бизнесийн тэр захирлыг түр зууртаа шүүхийн оролцоотойгоор сольж ажиллах нь тухай байхгүй юу. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч биш. Бид хэд энийг

тогтолцооны хувьд ойлгох ёстой. Өнөөдөр 10 хүн байдаг юм. Дандаа өмгөөлөгч суурьтай. Бас юмаа сайн ойлгохгүй. Тэгээд иймхэн юман дээр явж байгаа учраас энэ 200 хэдэн компани дотор чинь бараг 50, 60 мянган зомби компани байж байгаа.

Тэгээд өргөн барихдаа дагаж байгаа хуулиудыг жоохон сэглээд өгчхөж. Тийм учраас энэ дээр гишүүдийн асуугаад байгаа зүйлүүд байна. Тэгээд Энхбаяр сайд ч гэсэн нөгөө шинэчилсэн найруулга учраас та хэд ажлын хэсэг гараад, бүх зүйлүүдээ хөндөөд ярихад бэлэн бас хамтарч ажиллая гэж байгаа учраас энийг бас манай Байнгын хороо дэмжээд гаргах нь зүйтэй болов уу. Тэгээд яг энэ дээр илүү их сайн ярьдаг Цэнгүүн гишүүн маань оролцоосой гэж бодож байна. Эдийн засгийн background-тай хүмүүс ч гэсэн оролцоод явах нь зүйтэй. Тэгээд энэ дээр 2, 3 зүйл бий. Тэгэхдээ 1 зүйлийг бас ойлгоосой. Хууль бус буюу зохиомол дампуурлын асуудал чинь угаасаа эрүүгийн эрх зүйгээр зохицуулбал гэмт хэрэг. Тэгэхээр энийг бид хэд ялгаж өгч байж энэ гэмт хэрэг зөрчлөө ч гэсэн энэ иргэний кэйсээс .../минут дуусав/

О.Номинчимэг: Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн.

Х.Тэмүүжин: Уг нь би үг хэлэхгүй гэж бодсон юм. Хуулийн төслийг ер нь бол дэмжиж байгаа. Бид эдийн засгийн эрх чөлөөг бий болгоод, бизнес эрхлэлтийг дэмжье гэж бодож байгаа бол ямар нэгэн байдлаар update хийгээд, шинээр алдсан алдаанаасаа тэр чигээрээ тэндээ шидээд үлддэг биш, шинээр компаниуд, бизнес эрхлэгчид, цаашаа ингээд хөгжөөд явдаг тийм орон зайг бий болгохын тулд энэ төлбөрийн чадваргүйдэл болон энэ дампууралтай холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох ёстой. Тэгээд би энийг бол дэмжиж байгаа.

Сая харин Хууль зүйн яамнаас Хувийн эрх зүйн газрын дарга мэдээлэл хэлэхдээ энэ дампуурал болон төлбөрийн чадваргүй талаас гадна хэрвээ компани ингээд яах бол бүртгэлийн хуулиар тэр нөгөө санхүүгийн тайлан гаргаж өгөөгүй гэх мэтчилнээр алга болох тухай юу хэлчих шиг болох юм. Би бол харин тэр хуулийн эс эсрэг байгаа. Яагаад гэвэл захиргааны аргаар, шүүхийн аргаар компанийг татан буулгах юм уу, дампууруулахтай холбоотой асуудал энэ хуулиас гадуур байж ерөөсөө болохгүй шүү дээ. Одоо санхүүгийн тайлан гаргаж өгөөгүй гэдгээр бүртгэлийн хуулиар зүгээр бүртгэлээс хасдаг тийм сонин зохицуулалт хийгээд өгчихсөн байна лээ. Компаниудыг жагсааж байгаад хуулийн этгээдийн бүртгэлээс хасчихдаг. Тэгээд тэр чинь бол тэр компанийг яах гэж байгааг нь шийдэхгүйгээр зүгээр алга болчхож байна гэсэн үг шүү дээ. Балруулаад алга болгочхож байна гэсэн үг шүү дээ. Хууль зүйн хувьд бол тийм зохицуулалт байж ерөөсөө огт болохгүй. Тэр компани чинь газар эзэмшиж байгаа, ажлын байртай байгаа, өр, авлагатай байгаа, байж магадгүй шүү дээ. Тэгэхэд нь зүгээр л санхүүгийн тайлан гаргаж өгөөгүй учраас гээд зүгээр игнордоод балруулаад алга болгочхож байна гэдэг чинь эдийн засгийг огт ойлгодоггүй, хүмүүсийн компани болон бизнесийн энэ харилцааг огт мэддэггүй, зүгээр л цаасны ар дээр энэ байхгүй болно гээд биччихэд болно гэж боддог даргын л 1 хэлбэр шүү дээ. Харин энийгээ бид бол засах ёстой шүү. Нөгөөтээгүүр санхүүгийн тайлантай холбоотой асуудлаа ч гэсэн жоохон эргэж харах ёстой. Татварын тайлантай холбоотой асуудлыг бол ойлгож байна. Үндсэн хууль дээр заасан иргэний үүрэг байгаа. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал дээр санхүүгийн ямар тайланг ямар компанийн үйл ажиллагаатай холбоотойгоор төр авах, авахгүй гэдгийг нь ярихгүй бол зарим санхүүгийн тайлан гэдэг чинь хуулийн этгээдийн хувийн нууц шүү дээ. Бизнесийнх нь нууцын 1 хэсэг шүү дээ. Тэн дээр нь төр авна, өгөхгүй бол бүр чамайг байхгүй болгоно гэдэг ийм сонин философитой. Энэ чинь түрүүний бидний шүүмжилж яриад байгаа, манай

Дампуурлын тухай хууль чинь компанийг алга болгоход зориулсан тийм философитой бичигдсэн хууль гэж яриад байгаа мөртөө ард нь байгаа эдийн засгийн ийм алуур хийж байгаа хуулиудыг бас эргэж харахгүй бол Хууль зүйн яам Бүртгэлийн тухай хууль дээр их сонин зохицуулалт оруулаад тавьчихсан. Санхүүгийн тайланг компаниас нэхэж авах гэж байгаа бол төртэй харилцаанд орж байгаа компаниудаас л нэхэж авна шүү дээ. Тендерт орох гэж байгаа юмнуудаа .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Тэмүүжин гишүүний микрофоныг гүйцээгээд өгье.

Х.Тэмүүжин: Тэгснээс яг татварын тайлантайгаа адилхан бүх компаниас санхүүгийн тайлан авах ёстой гэж бодоод, нэхээд байх юм бол төрд энэ мэдээллээ өгөхийг хүсэхгүй байгаа, төртэй тэгэхдээ тусгай зөвшөөрлөөрөө юм уу, тендерээрээ юм уу, ямар нэг юмаар холбогдохгүй байгаа компаниудын хувьд энэ бол бизнесийнх нь эрх чөлөөний 1 хэсэг, бизнесийнх нь нууцын 1 хэсэг шүү дээ. Энэ төр захиргааны аргаар биш, санхүүгийн тайлан компаниуд гаргадаг байх нь хувь эзэмшигчдийг, хувьцаа эзэмшигчдийн эздийг мэдээлэлтэй байлгахад зориулагдсан зөвлөн туслах чиг үүрэг гэдгээ бас ойлгох хэрэгтэй шүү дээ. Энэ компанийг алга болгодог захиргааны буюу хариуцлагын механизм ерөөсөө биш гэдгийг бас ойлгох ёстой. Иймэрхүү зүйлүүдээ энэ хуулийг шинэчилж байх үйл явцдаа эдийн засгийнхаа төрийн оролцоотой холбоотой хэсэг дээр ойлгомжтой болгож авахгүй бол 1 гараараа ингээд компаниудын эрх чөлөөг дэмжих гээд байгаа юм шиг мөртөө, нөгөө гараараа захиргааны буюу зүгээр зөвлөн туслах чиг үүргийг захиргааны шийтгэлийн хариуцлагын механизм болгоод хувиргачихсан ийм байх юм бол нөгөө 2 дүртэй мангас шиг л болчхоод .../минут дуусав/

Д.Цогтбаатар: Номинчимэг гишүүний микрофоныг өгье.

О.Номинчимэг: Энэ хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг бол дэмжиж байгаа. Гэхдээ Улсын Их Хурал дээр бас нэлээн чамбай ажлын хэсэг гараад, эдийн засаг, санхүү, хууль, ялангуяа процессын энэ хуулийн мэдлэгтэй хүмүүс орж нэлээн сайн чамбайруулах шаардлагатай. Түрүүн асуултад дурдсан энэ төлбөрийн чадваргүйдэл гэдэг бүх юмны доор энэ ажиллагаануудыг бүгдийг нь бас хийчихсэн байгаа юм. Тэгээд төлбөрийн чадваргүйдлийн чинь хамгийн эцсийн 1 процесс буюу 1 арга tool нь бол дампуурал байхгүй. Тэгээд дампуурал гэдэг нэр томъёог ерөөсөө энэ хуулиас аваад хаячихсан. Дампуурлаа, дампуурал зарлалаа гээд энэ чинь өөрөө дахиад, дахин хуваарилалт хийх маш том эхлэл болдог юмыг энэ дээр холиод бас орчихсон байгааг цаашид ажлын хэсэг дээр энийг бүгдийг нь бас нарийн процессыг нь гаргаж ажиллах хэрэгтэй гэж харж байгаа. Тэгээд энийг хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, Улсын их Хурал дээр ажиллаад явах шаардлагатай гэж харж байгаа юм.

Тэгээд яах вэ, энэ хуультай холбоотойгоор ер нь бол бизнесийн орчин, хувийн хэвшлийн энэ орон зайг тэлэх асуудал дээр Улсын Их Хурал маш их анхаарах ёстой гээд олон ч удаа, олон ч хүмүүс ярьж байгаа. Тэгээд үүнтэй холбоотойгоор тэр иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хууль бол сайд дахиад өргөн барина гэж байх шиг байна. Ер нь бид нар 30-аад жил эдийн засгийн харилцаагаа яаж авч ирсэн юм. Юун дээр гажуудал гараад байгаа юм гэдэг дээр бас үнэлэлт, дүгнэлт өгөх асуудал бол манай суурь хууль Иргэний хуулийн асуудал байсан. Тэгээд ажлын хэсэг гараад манай Хууль зүйн байнгын хорооны нэлээдгүй олон гишүүн бас оролцоод 30 гаруй бас эрдэмтэн, судлаачид ороод, Иргэний хуулийн нийт заалтын

30 хувь дээр нь бол хэрэгжилтийн дүн шинжилгээ бол хийсэн байгаа. Энэ ажлын хэсгийн тайлан нэлээн зузаан гарчихсан.

Тэгээд зүгээр мэдээллийн чанартай хэлэхэд одоо ингээд Арилжааны хууль, арилжааны шүүх гээд олон санаанууд гарч байгаа боловч бид нар ямар дэс дараатай, ямар концепцтой хийх вэ. Иргэний хуулийн монаист тогтолцоогоороо явах юм уу дуалист болох юм уу. Тэгэх юм бол юун дээр анхаарах ёстой юм гэдэг асуудлыг бас онолын хүрээнд, бодлогын хүрээнд бас хэлэлцэх шаардлага байгаа. Тэгээд 3 сарын 3 юм уу, 4-нд энэ олон улсын бас нэг симпозиум буюу салбарынхныгаа оруулсан, тэр эрдэмтэд судлаачид ажилласан, Иргэний хуулийн хэрэгжилтийн тэр тайлангаа бид нар яриад, үнэхээр энэ дээр be to be харилцаан дээр байгаад байна уу. Эсвэл хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудал дээр нь доголдол гараад байгаа юм уу. Хуулийн нэр томъёонд байгаа юм уу, хэрэглээний асуудалд байгаа юм уу гэдэг асуудлыг бас цөмөөрөө хамтдаа хэлэлцэх байх. Үүнээсээ үүдээд бид нар эдийн засгийн харилцаан дахь тэр хувийн хэвшлийн орон зайг нээхэд юу юун дээр анхаарах ёстой вэ гэдгийг бас хэлэлцээд хаврын чуулгандаа ч гэсэн энэ чиглэлээр ажиллаад явах нь зүйтэй байх гэсэн бас мэдээллийн чанартай зүйлийг та бүхэнд хүргэе. Тэгээд хэлэлцэх эсэхийг дэмжиж байна.

Д.Цогтбаатар: Соронзонболд гишүүний микрофоныг өгье.

Л.Соронзонболд: Түрүүн Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль маань зөвхөн банк санхүүгийн зах зээлтэй холбоотой биш, бас олон компаниудын хоорондоо хийгддэг өдөр тутам хийгддэг олон үйл ажиллагааг зохицуулах гэж байгаа учраас энэ дээр яах вэ зүгээр хэлэхэд бол ийм байгаад байгаа юм. Жишээлбэл, зээлийн мэдээллийн санд жишээлбэл мэдээлэл нийлүүлэгдэж байгаа зээлдэгч нар банкнаас юм уу, банк бусаас зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хүмүүсээс зээл авсан хүмүүсийн мэдээлэл орж ирдэг. Тэнд бол тодорхой хэмжээнд зээлийн мэдээллийн сан байгаа учраас хүмүүс, аж ахуйн нэгжүүд бас илүү хариуцлагатай ханддаг ийм асуудал харагддаг.

Гэтэл яг бодит амьдрал дээр жишээлбэл юу гэдэг юм барилгын нэлээн томоохон компани доороо туслан гүйцэтгэгч компани аваад, мөнгийг нь өгдөггүй, гэрээнийхээ үүргийг биелүүлдэггүй иймэрхүү байдлууд их байдаг. Тэр тохиолдолд магадгүй Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн дагуу хүсэлт гаргаад, нөгөө тал нь гомдол гаргаад ингээд явах боломж энэ тэр бүрдэж байгаа гэдгээрээ бол энэ Төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль дээр бас дэмжих заалтууд бол байна гэж харж байна.

Гэхдээ гол нь болохоороо яах вэ гэхээр ер нь бид нар эцсийн энэ тухай хуулийг баталснаараа юуг сайжруулах гээд байгаа гэвэл энэ Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэх орчныг сайжруулах, компаниуд хоорондоо компаниуд хоорондоо харилцан итгэлцээд бизнес хийх боломжийг нь илүү нээх тал руугаа харж байгаа учраас бас тэр талын зохицуулалт дээр нь илүү цаашдаа яг ажлын хэсэг дээр бас нэлээн анхаарах ёстой юм болов уу гэж бодож байгаа юм. Тэр утгаар юу гэж хэлэх гээд байна гэхээр зүгээр жирийн компани хоорондын гэрээг хүртэл яг тэр зээлийн мэдээллийн сан шиг бүртгэж аваад, тэрнийхээ үүргийг цаг хугацаанд нь биелдэггүй юм уу, үгүй юм уу гэдгийг нь бүртгэдэг тийм мэдээллийн сан хүртэл байж болох байхгүй юу. Тэгэх юм бол тэр нь илүү шүүх гэхгүйгээр үйл ажиллагаа нь илүү сайжрах ч юм уу боломж нь байж магадгүй гэж бол харж байгаа. Тийм учраас ер нь

бол яах вэ Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг бол дэмжиж байна. Тэгээд цаашдаа ажлын хэсэгт нь ороод ажиллая л гэж бодож байна.

Д.Цогтбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. Би нэг хэдэн зүйл хэлчихье гэж бодож байна. Энэ ажлын хэсгийнхэн маань ярихдаа нэг ийм юм яриад байна шүү. Тийм учраас сая Тэмүүжин гишүүн яах аргагүй хэлж байна. Би энийг яг хэлнэ гэж бодож байсан юм. Энэ нэг буяны хууль орж ирээд, хүнийг дампуурахаас урьдчилан сэргийлээд, дараа нь restructuring буюу компанийг нь бараг засаж өгөөд, буцаагаад ажиллуулах гээд байгаа юм шиг тийм үзэл санаа энэ хуульд байхгүй шүү. Аль ч орны insolvency гэдэг чинь аливаа бизнес хийж байгаа хүнийг нийгэмд учруулах хор хохирлыг нь аль болох эртхэн тодорхойлж өгөөд, нийгмийг цаашдаа төөрөгдөөд, энэ хүн бизнестэй байгаад байгаа, бизнес хийх боломжтой байгаа гээд зээл өгөөд юм уу, бизнес үйлчилгээгээ үзүүлээд дараа нь зөвхөн тэр хүн хохироод, өөрөө дампуураад зогсох биш төлбөрийн чадваргүй болоод зогсох биш, өөр олон хүн чирээд явчихаас урьдчилан сэргийлж байгаа тэр утгаараа өөрөөр хэлбэл тэр сайн үр дагавар чинь энэ хуулийн хэрэгжилтийн явцад гарцаагүй дампуурах гэж байгаа хүнийг аль болох эрт бизнесээс нь гаргаж өгөх тэр талаараа бол буянтай.

Түүнээс хүнийг ингээд дампуурч байхад нь хүчээр бизнес хийлгэх энэ бизнесийн эрх чөлөөнд хардаа дампуурах хүртэл эрх чөлөө чинь бизнесийн эрх чөлөө байхгүй юу. Энд халдах тухай ойлголт ерөөсөө энэ хуульд байхгүй шүү. Энэ чинь нөгөө Германаас өөрөө манайхан явж судалж байж энэ хуулиа боловсруулсан учраас тийм бол санаа байхгүйг эртнээсээ бид нар ойлгож байх ёстой гэж бодож байна.

Энэ нэр томъёог ингэж хэрэглэж байгаа нь зөв шүү. Яагаад гэвэл дампуурлын хуультай байхаар асуудал юу болчихоод байна гэхээр нийгэмд үзүүлэх хор хохирол нь аль эрт ил болчихоод байдаг. insolvency буюу хэнд ч ойлгомжтой дампуурах гээд зөндөө олон банктай ийм юм болж байгаа шүү дээ. Эртхэн зогсоохгүй бол очиж нөгөөдөх чинь банк хэлбэрээрээ яваад, цаашдаа нийгэмд буцаагаад эргүүлээд үзүүлэх маш том хор хохирол, тэр нь улам нэмэгдээд байх, тэрнээс урьдчилж өөрөөр хэлбэл тэр дампуурахаас ч өмнө дампуурал гэдэг бол түрүүн Сайнзориг гишүүн хэлж байна лээ. Шүүхийн шийдвэр. Энэ маш тодорхой төлбөрийн чадваргүй болохоос гарах олон үр дагаврын зөвхөн нэг нь дампуурал байхгүй юу. Тэгээд тэр шүүхийн шийдвэрээр гарна. Гэтэл тэр нийгэмд учруулах хор хохирол чинь эрт үүсчихдэг учраас тэр дээр нь эрт энийг категори болгож ойлгож оруулж ирээд, хуульд суулгаад засаж байгаа нь бол маш зөв байгаа юм. Энэ утгаараа нийгмийг бас урьдчилан сэргийлэх энэ боломжийг нээж байгаа.

Энэ дээр харин Энхбаяр сайд аа, ийм юмыг хүмүүс түрүүн яриад байна. Хувь иргэний дампуурал, компанийн дампуурал 2 дээр яах вэ гээд. Энэ дээр бол орон болгон янз бүрээр шийддэг. Гэхдээ бид нар бол тусдаа байлгах нь зөв байх. Яагаад би тэгж бодож байгаа вэ гэхээр компани, хүн 2 хоёулаа хуулийн этгээд байдаг ч гэсэн үүсэж байгаа нөхцөл байдал өөр байхгүй юу. Компанийг чинь бол хүмүүс өөрсдөө бүр эрх зүйн процессоор явуулаад үүсгэж байгаа. Хүн бол тодорхой насанд хүрээд, хуулийн этгээд болоод нийгэмдээ оролцох хариуцлага юм нь үүсээд явдаг. Бүр үүсэхээсээ эхлээд огт өөр.

2-т жишээлбэл, хувьцаат компанийн дампуурлын асуудал, хувь хүний дампуурлын асуудал 2 чинь огт тусдаа. Нэгэн дээр нь тэр банкин дээр ликвидатор томилно. Хувь хүнийх дээр бол тийм асуудал байхгүй шүү дээ. Бүр том ялгаатай юм нь мэдээлэлд нэвтрэх боломж төрийн зүгээс шал өөр. Хувь хүнийх чинь бол нөгөө

хувь хүний эрх зүйн зохицуулалтуудаараа маш хаагдчихсан байдаг учраас энэ дээр бол энийгээ тусад нь гаргаж өгч явуулах нь зөв байх гэж бодож байна. Тэн дээр би Хууль зүйн сайдтай бас санал нэгдэж байна.

Энэ дээр энэ хуулийг засаж өгөхгүй бол гадаадын хөрөнгө оруулалт Монголд оруулж ирэхэд ёстой хэцүү. Хуучин манай хуулийн фирм байж байхад компаниуд байгуулж өгөөд арай гэж бизнесээ хийж байгаад, энд баахан улс төржилт болоод больё больё гээд гардаг. Компанийг нь татан буулгаж өгдөггүй. Нөгөө хүн чинь Монголын хуулийн хүрээнд бизнес байгуулчихсан бол хариуцлага нь тооцогдоод яваад байдаг. Тэгэхээр энэ юмыг нэгэнт хүн би бизнесээ татан буулгаад гараад явъя гэж байгаа бол тэрийг нь татан буулгахгүй барьцаалаад байгаа юм шиг 2, 3 жил үргэлжилдэг энэ процессыг бол нээрээ зогсоохгүй бол гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд бол энэ маш том сөрөг үр дагавартай болж бууж байгаа юм.

Түрүүн Соронзонболд гишүүний тэр хэлж байгаа зөв шүү. 3 сарын хугацаа өгөөд тэр өөрийн хөрөнгийн 30 хувьтай тэнцэх нөхцөл байдал үүсэхэд л энэ дээр хэрэг үүсгэх гээд байна шүү дээ. Гэтэл 2008 оных шиг том хямралын нөхцөл байдал бүрдчих юм бол зарим компаниуд чинь 6 сар ч байж болно. Тэгж байгаад босоод явчих компаниуд зөндөө байж байгаа шүү дээ. Тэгэхээр энийгээ бас явцын дундаа тооцож үзээрэй. Тэгээд түрүүн арилжааны бизнес шүүх байгуулж болох уу гэдэг дээр орон болгон өөр өөр байдаг. Ер нь Англо-Саксон хуультай орнуудад бүүр Англо-Саксон хуультай орнуудад нөгөө федерал тогтолцоо холбооны тогтолцоо байдаг учраас муж улс болгон нь өөрийн шүүхтэй. Энэ дээрээ өөрийн зохицуулалттай байдаг. Жишээлбэл Австралид бол муж улс болгонд ихэнхдээ дээд шүүхийнх нь дэргэд King's bench гэдэг байх. Английн ер нь систем Англид ч бас тийм. Их Британид ч тийм байгаа. Тэр Дээд шүүхийнх нь дэргэд яг тийм мэргэшсэн шүүхүүд бол байдаг. Тэгэхээр орон болгон өөр, энийгээ тус тусдаа л шийдсэн байдаг. Тэгээд тийм бас боломж бий. Тэрийгээ бас явцдаа харна биз. Тэгээд миний зүгээр өөрийн зүгээс санал болгох зүйл бол ийм байна. Ажлын хэсгийг зөвхөн Хууль зүйн байнгын хорооноос байгуулаад хэрэггүй байх. Ажлын хэсгийг бол Их Хурлын даргатай ярьж байгаад Хууль зүй байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооноос ч гэсэн хүмүүс оруулаад, түрүүн Цэнгүүн гишүүн бас ярьж байна. Тэгэхээр ер нь нэлээн өргөн хүрээтэй гишүүдийг оруулж байж ажлын хэсэг байгуулах ёстой. Тэрийг тэгэхээр Их Хурлын даргын захирамжаар гаргадаг. Тэр хэлбэрээр ажлын хэсгээ байгуулаад явах нь зөв байх гэж бодож байна. Ингээд миний хувьд бол юу асуудлыг дэмжиж байгаа.

Ингээд саналаа хураах хэлэлцүүлгийн шат руугаа оръё. Ингээд хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд байр сууриа илэрхийлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35.11-д заасны дагуу хуулийн төсөл түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулъя.

1.Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа бэлдэнэ үү. Манайхан бүгдээрээ өгөөрэй. Санал хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ. Сайн бүртгээрэй манайхан.

2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд

дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Түрүүчийн 1 дүгээр санал хураалтаар Эрдэнэболд гишүүн дэмжсэн байна. Дэмжсэнээр манайхан бүртгээд аваарай. Сая 57,9 хувиар санал дэмжигдлээ.

3.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

4.Арбитрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

5.Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

6.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

7.Векселийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

8.Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

9.Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

10.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 62,2 хувиар санал дэмжигдлээ.

11.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

12.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн

хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

13.Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

14.Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

15.Компанийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

16.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

17.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

18.Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

19.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

20.Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

21.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 52,6 хувиар санал дэмжигдлээ.

22.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

23.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

24.Улс төрийн намын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

25.Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

26.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 62,2 хувиар санал дэмжигдлээ.

27.Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

Түрүүний энэ 62 гэж би уншаад байсан бол 63,2 хувиар дандаа байгаа шүү. Тэрийг бас засаж тэмдэглээрэй.

28.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

29.Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

30.Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

31.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

32.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

33.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

34.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

35.Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

36.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

37.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

38.Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

39.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

40.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 57,9 хувиар санал дэмжигдлээ.

41.Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 63,2 хувиар санал дэмжигдлээ.

Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг танилцуулна. Баярбаатар гишүүн уншиж танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Номинчимэг гишүүн Их Хурлын нэгдсэн чуулганд уншиж танилцуулна.

18.10 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ